

Аудит хийгдсэн байгууллага: "Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК

ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ  
ДОТООД АУДИТЫН ХОРОО

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН

2024 он

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ4000

АУДИТ ХИЙСЭН  
БАЙГУУЛЛАГА:

ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН  
САЙДЫН ДЭРГЭДЭХ “ДОТООД АУДИТЫН ХОРОО”

АУДИТ ХИЙГДСЭН  
БАЙГУУЛЛАГА:  
АУДИТЫН ТӨРӨЛ:

“ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ” ТӨХХК  
ДОТООД АУДИТ

АУДИТЫН ХУГАЦАА:

2024.10.25-2024.11.29

Ажлын хэсгийн ахлагч:

Х.Ган-Очир

Хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод  
аудитын газрын дарга

Гишүүн:

А.Гэрэлт-Од

Хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод  
аудитын газрын, ахлах шинжээч

Д.Мөнгөнсүвд

Хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод  
аудитын газрын, ахлах шинжээч

Ц.Ууганбаяр

Хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод  
аудитын газрын шинжээч

Л.Оюумаа

Хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод  
аудитын газрын шинжээч

Нарийн бичгийн дарга:

Б.Цолмон-Эрдэнэ

Хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод  
аудитын газрын шинжээч

АГУУЛГА

1. ТАНИЛЦУУЛГА
2. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ
  - 2.1 Аудитын зорилго
  - 2.2 Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт
  - 2.3 Аудитын арга, аргачлал
3. БАЙГУУЛЛАГЫН ТАНИЛЦУУЛГА
4. БАЙГУУЛЛАГЫН САЙН ТУРШЛАГА
  - 4.1 Засаглалын талаар
  - 4.2 Эрсдэлийн удирдлагын талаар
  - 4.3 Дотоод хяналтын системийн талаар
5. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА
  - 5.1 Санхүүгийн үйл ажиллагааны талаар
  - 5.2 Төрийн өмчийн түрээсийн орон сууцыг түрээслүүлэх, өмчлүүлэх ажлыг нийслэлд зохион байгуулах ажлын талаар
  - 5.3 Нийслэлд баригдсан орон сууцны авто зогсоол, зоорийн давхар, агуулах, үйлчилгээний төвийн суурийг худалдан борлуулах, борлуулалтын орлогын төвлөрүүлэлтийн талаар
  - 5.4 Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар
6. АУДИТЫН ҮР ДҮН
7. НЭГДСЭН ДҮГНЭЛТ

## 1. ТАНИЛЦУУЛГА

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын дэргэдэх “Дотоод аудитын хороо”-ны 2024 оны төлөвлөгөө, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”, Сангийн сайдын 2019 оны 29 дүгээр тушаалаар батлагдсан “Дотоод аудитын хорооны дүрэм, 2019 оны 268 дугаар тушаалаар баталсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”-ын дагуу “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн үйл ажиллагаанд дотоод аудит хийсэн тайланг танилцуулж байна.

## 2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

### 2.1 Аудитын зорилго:

“Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, дүгнэлт, санал, зөвлөмж өгөх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, удирдлагыг мэдээллээр хангахад оршино.

### 2.2 Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт

“Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн үйл ажиллагаанд дотоод аудитыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Төрийн өмчийн түрээсийн орон сууцыг түрээслүүлэх, өмчлүүлэх ажлыг нийслэлд зохион байгуулах;
- Нийслэлд баригдсан орон сууц, авто зогсоол, зоорины давхар, агуулах, үйлчилгээний төвийн суурийг худалдан борлуулах, борлуулалтын орлогын төвлөрүүлэлт;
- 2024 оны хагас жилийн байдлаарх санхүүгийн үйл ажиллагаанд;
- Дотоод хяналт хэрэгжүүлсэн байдалд;
- Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт;
- Аудит, хяналт шалгалтын тайлан, зөвлөмжийн хэрэгжилт;
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.

### 2.3 Аудитын арга, аргачлал

“Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн удирдлагад дотоод аудитын зорилго, хэрэгжүүлэх зарчмаа танилцуулж, засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын тогтолцооны талаар асуулга авсан. Мөн аудитын хамрах хүрээнд багтаасан асуудлуудын хүрээнд байгууллагын үйл ажиллагаа, санхүүгийн байдал зэргээс олж авсан мэдээлэл, бичиг баримтад дүн шинжилгээ хийж, түүврийн аргаар сорил хийлээ. Аудитын эдгээр горимын үр дүнд, дотоод аудитын баг хангалттай аудитын нотолгоо цуглуулж, аудитын дүгнэлтээ гаргасан болно. Дотоод аудитыг хэрэгжүүлэхэд дараах хууль эрх зүйн баримтуудыг эх үүсвэр болгон ашиглалаа.

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Компанийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн өмчийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Хот байгуулалтын тухай хууль
- Барилгын тухай хууль
- Орон сууцны тухай хууль
- Дотоод аудитын олон улсын мэргэжлийн практикийн хүрээ /ОУМГХ/
- Улсын салбарын дотоод аудитын гарын авлага
- Монгол улсын Засгийн газрын 2015 оны 248 дугаар тогтоолоор баталсан

“Түрээсийн орон сууц” хөтөлбөр

- Засгийн газрын 2019 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 138, 2020 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 216 дугаар тогтоол, “Түрээсийн орон сууцыг өмчлүүлэх журам”

- Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 26 дугаар тушаалаар батлагдсан “Зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам”

- Төрийн орон сууцны корпорацийн ерөнхий захирлын 2017 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/45 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн өмчийн орон сууцанд зорилтот бүлгийн иргэдийг бүртгэх, сонгон шалгаруулах, түрээсийн орон сууцанд хамруулах ажлыг зохион байгуулах журам”
- Бусад эрх бүхий байгууллагаас хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан тогтоол, шийдвэрүүд

### 3. БАЙГУУЛЛАГЫН ТАНИЛЦУУЛГА

“Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК нь Монгол Улсын хүн амыг хямд өртөгтэй, чанартай орон сууцаар хангах төрийн бодлого, төрөөс зорилтот бүлгийн иргэдийг орон сууцаар хангах хөнгөлөлтийн бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий 100 хувь /хувьцааг нь төр эзэмшдэг/ төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани юм.

#### АЛСЫН ХАРАА:

Төрийн бодлогын хүрээнд иргэдийн орлого, хэрэгцээнд нийцсэн, чанартай, ногоон шийдэл бүхий орон сууцаар хангана.

#### ЭРХЭМ ЗОРИЛГО:

Хүн амыг хямд өртөгтэй, чанартай орон сууцаар хангах төрийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалт, санхүүгийн цогц үйл ажиллагааг явуулахад оршино.

#### ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

- Монгол Улсын хүн амыг хямд өртөгтэй, чанартай орон сууцаар хангах төрийн бодлогыг хэрэгжүүлэх
- Төрөөс зорилтот бүлгийн иргэдийг орон сууцаар хангах хөнгөлөлтийн бодлогыг хэрэгжүүлэх
- Хууль, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, бусад зорилтот орон сууцны төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

#### БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ

“Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн ТУЗ-ийн 2023.11.21-ний өдрийн 13 тоот тогтоолоор Компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг баталсан.

Орон тооны дээд хязгаарыг үндсэн ажилтан 39, гэрээт ажилтан 15+38 /53/ байхаар тогтоосон. Өнөөдрийн байдлаар ажиллаж буй үндсэн 34, гэрээт 14, нийт 48 ажилтнаас 21 нь эрэгтэй, 27 эмэгтэй ажилтан байна. Үүнээс удирдах албан тушаалд 3 эрэгтэй, 3 эмэгтэй ажилтан байна.

#### ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД

Улаанбаатар хот болон орон нутагт 548.5 тэрбум төгрөгийн төсөв бүхий төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж 7491 иргэнд зээл олгож 10 жилийн хугацаанд нийт 12650 өрх орон сууцтай болсон.

№	ОРОН СУУЦНЫ ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛИЙН САНХҮҮЖИЛТЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСЛҮҮД	Зээлдэ гчийн тоо	Төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн хугацаа	Санхүүжилт /тэрбум төгрөг/	Зээлийн нөхцөл /хувь/
1	“40 000 АЙЛЫН ОРОН СУУЦ” хөтөлбөр /УБ хот, 21 аймаг, 58 сум/	1,620	2006-2009	32.7	11
2	“4000 АЙЛЫН ОРОН СУУЦ” төсөл /төрийн албан хаагч/	4,566	2010-2014	154.8	8
3	“100 000 АЙЛЫН ОРОН СУУЦ” хөтөлбөр	1,305	2011-2014	51.3	8
	Нийт	7491			

№	ОРОН СУУЦНЫ БАРИЛГЫН САНХҮҮЖИЛТЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСЛҮҮД	Орон сууцны тоо /айл/	Төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн хугацаа	Санхүүжилт /гэрбум төгрөг/	1 метр квадрат талбайн үнэ
4	"БУЯНТ-УХАА 1" төсөл	1,767	2013-2014	95.7	1.280,0
5	"БУЯНТ-УХАА 2" төсөл /Түрээсийн орон сууцны санд 564 айлын орон сууцыг шилжүүлсэн/	2,592	2014-2016	172.5	1.350,0
Орон нутагт: /Архангай 120, Дархан-Уул 189, Сэлэнгэ126, Увс 105, Ховд 120, Хэнтий 120, Хэнтийн Бор-Өндөр 20/					
6	"АЙМАГ БҮРТ 1000 АЙЛЫН ОРОН СУУЦ" төсөл	800	2014-2016	41.5	1.150,0- 1.280,0
	Нийт	12650		548.5	

№	ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ БОЛОН ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨСӨН ТӨСӨЛ	Төлөвлөлт				Санхүүжилт /гэрбум төгрөг/
		Орон сууцны тоо /айл/	Барилгыг давхрын тоогоор	Блок /тоо/	Талбай /га/	
1	"ЭКО ЯАРМАГ-1" төсөл /2021-2026/	2,304	7, 9, 16, 25	39	8.2	275
2	"СОЛОНГО-1" /mon18/, "СОЛОНГО-2" /mon19/ төсөл /2021-2027/	5,002	9	66	17.19	266.8 сая доллар
3	"ЗАЛУУС-1" төсөл /2021-2026/	5,616	5, 6, 7, 8, 9	94	57	1.6 их наяд төгрөг
4	Хэнтий, Хөвсгөл, Ховд, Архангай аймагт хэрэгжүүлэх төслүүд /2023-2026/	1,020	-	-	8.5	97.7

#### 4. БАЙГУУЛЛАГЫН САЙН ТУРШЛАГА

##### 4.1. Засаглалын талаар

Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 37 дугаар тогтоолоор "Орон сууцны үндэсний төв"-ийг үүсгэн байгуулсан бөгөөд мөн оны Засгийн газрын 200 дугаар тогтоолоор "Орон сууцны санхүүжилтийн корпораци" ХХК болгон өөрчилсөн. Засгийн газрын 2013 оны 253 дугаар тогтоолоор "Төрийн орон сууцны корпораци" ТӨҮГ, Засгийн газрын 2018 оны 328 дугаар тогтоолоор "Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК болж батлагдсан.

Компанийн удирдлага дараах бүтэцтэй байдаг.

1. Хувьцаа эзэмшигчдийн хурал
2. Төлөөлөн удирдах зөвлөл
3. Гүйцэтгэх удирдлага

Компанийн хувьцаа эзэмшигчийн эрхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар хэрэгжүүлж, Хувьцаа эзэмшигчдийн хурал нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаан байдаг. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 701 дугаар тогтоолоор "Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК-ийн 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталж, 2024 оны 548 дугаар тогтоолоор "Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК-ийн 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг тодотгон баталсан байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын "Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай" 2023 оны 525 дугаар тогтоолын дагуу 31 төрийн өмчит ХХК-уудад 2021, 2022 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн. "ТОСК" ТӨХХК нь 11



асуудлын хүрээнд 21 төрлийн баримт материалыг шалгуулж, 97.5%-тай дүгнүүлсэн сайн туршлагатай байна.

Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл бодлогыг тодорхойлдог 9 гишүүний бүрэлдэхүүнтэй хувьцаа эзэмшигчдийн хурлаас сонгогдсон мэргэжлийн хуульд тавьсан шаардлагыг бүрэн хангасан төлөөллүүдээс бүрдсэн байна. 2024 онд нийт 7 удаа хуралдсан байна.

Компанийн гүйцэтгэх удирдлага нь гүйцэтгэх захирал, компанийн дүрэм болон Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан контрактад заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулдаг. Гүйцэтгэх удирдлага Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 23 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн дүрмийн 10.7-д заасан гүйцэтгэх захирлын шалгуурыг хангасан туршлагатай, мэргэшсэн удирдлага байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн дүрмийн 10.10.10-т зааснаар Гүйцэтгэх захирал компанийн үйл ажиллагаатай холбогдох асуудлаар 2023-2024 онуудад дараах дүрэм, журмыг шинэчлэн баталсан байна. Үүнд:

1. “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын 2023 оны А/30 дугаар тушаалаар “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн дэргэдэх “Ёс зүйн зөвлөлийн ажиллах журам”
2. “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын 2023 оны А/63 дугаар тушаалаар “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах журам”
3. “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын 2024 оны А/22 дугаар тушаалаар компанийн “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”
4. “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын 2024 оны А/23 дугаар тушаалаар компанийн “Дотоод аудитын үйл ажиллагааг зохион байгуулах журам”
5. “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын 2024 оны А/24 дүгээр тушаалаар компанийн “Хүний нөөцийн сонгон шалгаруулалтын журам”, А/36 дугаар тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулсан
6. “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын 2024 оны А/51 дугаар тушаалаар “Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн батлах тухай”.

**ТҮРЭЭСИЙН ТӨЛБӨРИЙГ ХУГАЦААНД НЬ ТӨВЛӨРҮҮЛЖ, ХУРИМТЛАГДСАН АВЛАГЫГ БУУРУУЛЖ АЖИЛЛАСАН ТУХАЙ:**

“Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/32, А/61, А/62 тоот тушаалуудаар 2024.03.25-ны өдрөөс 2024.04.05-ны өдрүүдэд Ховд, Увс, Архангай, Баянхонгор аймгуудаар, 2024.07.25-28-ны өдрүүдэд Хэнтий аймгийн Чингис хот, Бор-Өндөр сум, 2024.08.19-22-ны өдрүүдэд Дархан Уул аймаг, Сэлэнгэ аймгийн Мандал сумуудаар албан томилолтоор ажилласан.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 38, 169 дүгээр тогтоол “Түрээсийн орон сууц” хөтөлбөрт хамрагдсан иргэдийн гэрээний биелэлтэд хяналт шалгалт хийж, төлбөрийн үлдэгдэл ихтэй айлуудын төлбөр барагдуулж ажилласан.

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ4000

ТҮРЭЭСИЙН ТӨЛБӨР	БУХаа2, Хангай хотхон		Орон нутаг	
	Өрхийн тоо	Авлагын дүн /сая₮/	Өрхийн тоо	Авлагын дүн /сая₮/
Хуримтлагдсан авлага	226	273.5	135	165.4
Төлүүлсэн авлага	165	170.0	114	92.5
Нийт	391	103.5	249	72.9

Орон нутагт

№	Хотхон	Төвлөрүүлэх орлого	Төвлөрсөн орлого	Гүйцэтгэлийн хувь
Баянхонгор аймгийн Баянхонгор сум /2024.03.25/				
1	30 айлын орон сууц /Тус байрны зорийн давхрыг 3 хуваан эзэмшиж байна. Ашиглагдахгүй удсан зорийн давхарт өөрсдийн хөрөнгөөр засвар хийж, түрээсийн төлбөр төвлөрүүлж ажиллаж байна/		1. "Цэлмэг өглөө" архинаас гаргах төв, орон нутгийн ЗДТГ-аас 20 сая төгрөгний засвар 2. Иргэн Л.Нэргүй, "Бялдаржуулах төв" нээж, 10 сая төгрөгний засвар 3. "Сургалтын төв" 1-р сургуулийн химийн багш Баянмөнх нээж, 5 сая төгрөгний засвар	
Ховд аймаг Ховд сум /2024.03.26-28/				
2	"Бугат" 120 айлын орон сууцны хороолол	41,8 сая	29,8 сая	71%
Увс аймгийн Улаангом сум /2024.03.29-04.01/				
3	"Галданбошигт" 105 айлын орон сууцны хороолол	41,4 сая	26,3 сая	64%
Архангай аймгийн Цэцэрлэг сум /2024.04.02-04/				
4	"Булганхангай" 120 айлын орон сууцны хороолол	47 сая	25,5 сая	54%
Хэнтий аймгийн Чингис хаан хот /2024.07.27-28/				
5	30 айлын орон сууц	4 сая	1,5 сая	37.5%
6	Бор-Өндөр хороолол /20 айл/	6,5 сая	3,0 сая	46%
7	Шинэ Өндөрхаан хороолол /115 айл/	19,3 сая	11,3 сая	19%
Дархан Уул аймаг /2024.08.19-20/				
8	Наран хотхон 152 айл	41 сая	33 сая	80%
Сэлэнгэ аймаг Мандал сум /2024.08.20-22/				
9	Ширхэнцэг Мандал	70 сая	61 сая	70%
	НИЙТ	271 сая	191,4 сая	70,6%

ТҮРЭЭСИЙН ГЭРЭЭНИЙ СУНГАЛТ ХИЙСЭН ТАЛААР:

Орон нутагт

№	Хотхон	Цахим хаяг болон утасны дугаарын шинэчлэлт	Сул байр	Түрээсийн гэрээний сунгалт	Өмчлөх гэрээ
Ховд аймгийн Ховд сум /2024.09.20-20/					
1	"Бугат" 120 айлын орон сууцны хороолол	46 түрээслэгч	1 цуцлах гэрээ	14 айл	Б-1 тоот



ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ4000

Увс аймгийн Улаангом сум /2024.03.29-04.01/					
2	“Галданбошиг” 105 айлын орон сууцны хороолол	34 түрээслэгч	-	11 айл	-
Архангай аймгийн Цэцэрлэг сум /2024.04.02-04/					
3	“Булганхангай” 120 айлын орон сууцны хороолол	35 түрээслэгч	-	15 айл	-
Хэнтий аймгийн Чингис хаан хот /2024.07.27-28/					
4	30 айлын орон сууц	4 түрээслэгч	1 байр /6 тоот, 2 өрөө/	-	-
5	Бор-Өндөр хороолол /20 айл/	6 түрээслэгч	-	5	-
6	Шинэ Өндөрхаан хороолол /115 айл/	34 түрээслэгч	-	-	-
Дархан Уул аймаг /2024.08.19-20/					
7	Наран хотхон 152 айл	-	-	-	1-65 тоот, 2-33 тоот
Сэлэнгэ аймаг Мандал сум /2024.08.20-22/					
8	Ширхэнцэг Мандал	-	-	-	-
НИЙТ		159	2	45	3

ОРОН СУУЦНЫ АШИГЛАЛТЫН ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГУУЛАХ, ЗӨРЧЛИЙГ АРИЛГУУЛАХ ТАЛААР:

“ТОСК” ТӨХХК-ийн Гүйцэтгэх захирлын А/17 тоот тушаалаар байгуулагдсан “Төрийн түрээсийн орон сууц түрээслэх гэрээ”-ний заалтуудыг зөрчсөн иргэдэд хариуцлага тооцсон байна.

№	Хотхон	Зөрчил	Орон сууц ашиглалт
Ховд аймаг Ховд сум /2024.03.26-28/			
1	“Бугат” 120 айлын орон сууцны хороолол	Нэг оршин суугч гэрээ цуцлах мэдэгдэл авсан. Өмнө нь хуримтлагдсан авлагыг үлдэгдлийн зөрүүн дээр тооцоо нийлэхээр болсон.	-
Увс аймгийн Улаангом сум /2024.03.29-04.01/			
2	“Галданбошиг” 105 айлын орон сууцны хороолол	Барилгыг ашиглалтанд өгөхдөө дулаан, цахилгаан хүлээлгэж өгөөгүй. Хариуцсан СӨХ байхгүйгээс байрны ашиглалтад гарсан асуудлыг шийдэж өгдөггүй.	Дулаан алдагдал ихтэй, халаалт сайн ирэхгүй, хананаа дагаж цанатаж, хөлөрсөн, хөлдсөн.
Архангай аймгийн Цэцэрлэг сум /2024.04.02-04/			
3	“Булганхангай” 120 айлын орон сууцны хороолол	Хуримтлагдсан авлагаа төлж барагдуулахгүй байгаа иргэдэд өмчлөх гэрээ хийхгүй болохыг сануулав.	-
Хэнтий аймгийн Чингис хаан хот /2024.07.27-28/			

4	Бор-Өндөр хороолол /20 айл/	- 16 тоотод гэрээ баталгаажаагүй иргэн Н.Чинбат амьдарч байсан зөрчил илэрсэн. Хэнтий аймаг дахь ТОСК-ийн гэрээт ажилтан Ч.Эрдэнэ-Очирын зөвшөөрлөөр 2024.07.01-ний өдрөөс засвар хийж орсон. 2024.08.10-ны өдөр гэхэд байр чөлөөлсөн байх, шаардлага тавьсан.	2024.07.01-ний өдрөөс иргэн Н.Чинбат засвар хийж орсон боловч дээд айлын ариун цэврийн өрөөний сантехникийн хоолойноос ус алдснаас болж доод айл болон орцны таазны шохой ховхорч унасан, коридорын ханын обой шарлаж хууларсан, хөгц ургасан байдалтай байсан.
5	30 айлын орон сууц	Нийт орон сууцнууд дээврийн чанараас шалтгаалан бороо, цас их хэмжээгээр орсоны улмаас дээврээс ус гоожих, байрны суурийг дагаж зорийн давхар усанд автсан байдалтай байна. Сантехникийн шугам муудснаас тааз, хананаас ус алдсан гомдол их байна. Хаалга, цонх, шал муудснаас дулаан алдагдал ихтэй байна гэж гомдолсон.	
6	Шинэ Өндөрхаан хороолол /115 айл/		
Дархан Уул аймаг /2024.08.19-20/			
7	Наран хотхон 152 айл	Төлбөрийн үлдэгдэл ихтэй, гэрээ сунгах, төлбөр төлөх хугацааг хойшлуулах хүсэлтэй иргэд өргөдлөө өгсөн.	
Сэлэнгэ аймаг Мандал сум /2024.08.20-22/			
8	Ширхэнцэг Мандал	Оршин суугчдаас бохир ихээхэн хальдаг талаар удаа дараа гомдол ирсэн асуудлыг Сэлэнгэ аймаг дахь Эрчим хүч, ус хангамжийн төвтэй холбон, үүссэн асуудлыг дор бүр нь мэдэгдэж байхыг сануулсан.	Сантехникийн шугам муудснаас ус ойр, ойрхон тасрах, бөглөрч бохир халих, ус халих

#### 4.3. Эрсдэлийн удирдлагын талаар

“Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн Б/55 тоот тушаалаар “MNS ISO 37001 Авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцоо, шаардлага ба хэрэглэх удирдамж стандарт”-ыг компанийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан сайн туршлага байна. “MNS ISO 37001 Авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцоо, шаардлага ба хэрэглэх удирдамж стандарт”-ыг үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр:

- ✓ Нэр хүндийн эрсдэл гэх мэт авлига болон түүнтэй холбоотой эрсдэлийг тодорхойлж, удирдах;
- ✓ Авлигын эсрэг менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх жишиг тогтоож, шаардлага тавьж, зааварчилгааг дэмжих;
- ✓ Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, хариу арга хэмжээ авах талаар удирдах байгууллага, удирдлага, хөрөнгө оруулагчид, боловсон хүчин, үйлчлүүлэгчид, зохицуулагчид болон бусад оролцогч талууд зэрэг холбогдох талуудад баталгаа өгөх;
- ✓ Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хээл хахуулийн эрсдэлийг бууруулах
- ✓ Хамгийн гол нь ил тод, шударга байх соёлыг бий болгох зэрэг эерэг үр дүнтэй.

“MNS ISO 37001 Авлигатай тэмцэх ажлын менежментийн тогтолцоо, шаардлага ба хэрэглэх удирдамж стандарт”-ыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх ажлын хүрээнд ажлын хэсэг дараах 9 журмыг боловсруулж байгаа.

1. Мэргэжлийн судалгаа (due diligence);
2. Санхүүгийн хяналт;
3. Санхүүгийн бус хяналт;
4. Хяналтад хамрагдсан байгууллага болон бизнесийн холбоотноос хэрэгжүүлэх авлигын эсрэг хяналт;
5. Авлигатай тэмцэх амлалт мэдэгдэл;
6. Бэлэг сэлт, найр тавин тал татах хандлага, хандив тусламж, түүнтэй ижилсгэх бусад зүйл;
7. Авлигатай тэмцэх хяналтын үл зохицлыг удирдах;
8. Гомдол мэдүүлэх;
9. Авлигын зөрчлийг илрүүлэх, зохицуулах.

2024 оны 10 дугаар сарын 10-ны өдөр байгууллагын нийт 15 ажилтан үндсэн, 6 гэрээт ажилтнаас байгууллагын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа, төсөв санхүү, хүний нөөц зэрэг асуудлаар санал асуулга авч судалгаагаар нийт 26 эрсдэлийг тодорхойлж үнэлсэн ба 11 эрсдэлийг маш бага, 14 эрсдэлийг бага, 1 эрсдэлийг дунд гэж тодорхойлсон байна.

#### 4.4. Дотоод хяналтын системийн талаар

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-н дагуу Төрийн орон сууцны корпорацийн гүйцэтгэх захирлын 2024 оны А/22 дугаар тушаалаар “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”, 2024 оны А/23 дугаар тушаалаар “Дотоод аудитын үйл ажиллагааг зохион байгуулах журам”-г тус тус батлуулан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

“Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 11 дүгээр сарын 21-ны өдрийн 13 дугаар тогтоолын дагуу “ТОСК” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын 2023 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн А/64 дүгээр “Ажил мэргэжлийн жагсаалт болон албан тушаалын сарын үндсэн цалингийн сүлжээг шинэчлэн батлах тухай” тушаалаар компанийн бүтэц, орон тоог шинэчлэн баталсан байна. Шинэ бүтцээр дотоод хяналтын чиг үүргийг нэмж дотоод хяналтын системийг сайжруулах тал дээр анхааран ажилласан байна. Хууль, эрх зүй, дотоод хяналтын газар 6 хүний бүрэлдэхүүнтэй ба Дотоод хяналтын мэргэжилтэн, Дотоод аудит хариуцсан мэргэжилтэн нар дотоод хяналтыг хариуцдаг.

Төрийн орон сууцны корпорацийн гүйцэтгэх захирлын 2024 оны А/25 дугаар тушаалаар “Дотоод аудит, хяналт шалгалтын төлөвлөгөө”-г батлуулсан байна.

## 5. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 5.1 Санхүүгийн үйл ажиллагааны талаар:

“Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК нь 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн байдлын тайланд 154,698,647,341.75 төгрөгийн эргэлтийн, 68,562,629,990.14 төгрөгийн эргэлтийн бус, нийт 223,261,277,331.89 төгрөгийн хөрөнгө тайлагнасан байна.



ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ4000

Мөрийн дугаар	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	4,575,957,777.52	3,245,111,750.89
1.1.2	Дансны авлага	52,602,996,859.24	51,716,354,704.75
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	4,430,103.21	10,411,283.75
1.1.4	Бусад авлага	207,163,890.29	207,163,890.29
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	0.00	0.00
1.1.6	Бараа материал	11,314,465,171.42	11,645,231,541.69
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	0.00	250,000.00
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	88,374,179,646.22	87,874,124,170.68
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	<b>156,479,193,447.90</b>	<b>154,698,647,341.75</b>
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	972,053,366.83	1,019,303,891.86
1.2.2	Биет бус хөрөнгө	67,545,438,436.66	67,542,326,098.28
1.2.3	Биологийн хөрөнгө	0.00	0.00
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	1,000,000.00	1,000,000.00
1.2.5	Хайгуул ба үнээлгээний хөрөнгө	0.00	0.00
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	0.00	0.00
1.2.7	Хөрөнгө орлуулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	0.00	0.00
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	<b>68,518,491,803.49</b>	<b>68,562,629,990.14</b>
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>224,997,685,251.39</b>	<b>223,261,277,331.89</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
2.1	<b>ӨР ТӨЛБӨР</b>		
2.1.1	Богнино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	56,291,447,035.86	56,180,092,531.31
2.1.1.2	Цалингийн өглөг	815,584.14	1,287,147.07
2.1.1.3	Татварын өр	31,049,726.58	773,586.95
2.1.1.4	НДШ-ийн өглөг	0.00	0.00
2.1.1.5	Богнино хугацаат зээл	0.00	0.00
2.1.1.6	Хүүний өглөг	462,376,712.32	462,376,712.33
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	0.00	0.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	11,089,768,020.51	12,604,086,519.17
2.1.1.9	Нооц / өр төлбөр /	0.00	0.00
2.1.1.10	Бусад богнино хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) - ид хамаарах өр төлбөр	0.00	0.00
2.1.1.13	Богнино хугацаат өр төлбөрийн дүн	<b>67,875,457,079.41</b>	<b>69,248,536,496.83</b>
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	24,629,279,556.37	24,630,556,400.37
2.1.2.2	Нооц / өр төлбөр /	0.00	0.00
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	0.00	0.00
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	202,500,000,028.69	207,200,000,028.69
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	<b>227,129,279,584.86</b>	<b>231,830,556,428.86</b>
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>295,004,736,664.27</b>	<b>301,079,092,925.69</b>
2.3	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Төрийн өмч	88,000.00	88,000.00
2.3.2	Хувийн өмч	0.00	0.00
2.3.3	Хувьцаат өр төлбөр	0.00	0.00
2.3.4	Халаасны хувьцаа	0.00	0.00
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	17,000,270.98	17,000,270.98
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	60,328,787.00	60,328,787.00
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нооц	0.00	0.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	66,698,133,880.00	66,698,133,880.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-136,782,602,350.86	-144,593,366,531.78
2.3.11	Эздийн өмчийн дүн	<b>-70,007,051,412.88</b>	<b>-77,817,815,593.80</b>
2.4	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>224,997,685,251.39</b>	<b>223,261,277,331.89</b>

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ .....

ЕРӨНХИЙ НАЯТЛАН БОДОГЧ .....

//Б.Эрдэнэбулган//

//Н.Нямдулам//



Мөнгөн хөрөнгийн талаар:

Мөнгөн хөрөнгө дансанд 2024 оны эхний хагас жилийн байдлаар 3,2 тэрбум төгрөгийн үлдэгдлийг тайлагнасан байна.

2024.06.30-ны байдлаарх жижиг мөнгөн сан ба касс, 6 банкны 22 дансны нийт үлдэгдэл 3,245,111,747.14 төгрөг байна.

		2024/06/30
№	Дансны нэр	Үлдэгдэл
1	Кассанд байгаа бэлэн мөнгө (төгрөг)	18,185,639.99
2	ХХБ 411016369 Үйл ажиллагаа	1,125,391.26
3	Капитрон банк 304004444	39,212.67
4	ХААН банк /5099007040/ Борлуулалтын орлого	2,336,655.68
5	ХХБанк /413008020/ Борлуулалтын орлого	111,449.12
6	Голомт /2205048202/ Борлуулалтын орлого	10,927,372.23
7	Төрийн банк-104400343831	28,169.58
8	Төрийн банк - 343200413090/Түрээсийн орон сууц/	187,496,392.34
9	төрийн банк - 103900830078 /түрээсийн орон сууц УБ/	251,882,915.84
10	Төрийн банк-/346900196237 борлуулалт төвлөрүүлэлт/	90,193.58
11	Капитрон банк 3001022999/түрээсийн орлого/	166,216,186.60
12	Капитрон банк 3036031919/түрээсийн орлого/	171,755,187.99
13	ХААН банк /5027951642/ Түрээсийн орлого	6,901,365.75
14	Капитрон банк3040022999/ Түрээсийн барьцаа/	1,131,088,459.55
15	Төрийн банк 34380000214443	1,176,499,000.22
16	Төрийн банк 104401881355 / үйл ажиллагаа /	24,237,908.51
17	Төрийн банк /104401887232/ Борлуулалтын орлого	22,953,837.00
18	Төрийн банк / 104401887231/ Түрээсийн орлого	65,300,692.14
19	Төрийн банк 380000225147 / хадгаламж/	9,506.85
20	Хөгжлийн банк 3600000549 Төслийн санхүүжилт	7,441,789.21
21	ХХБанк /413008019/ Төслийн санхүүжилт	48,286.95
22	Голомт банк /2205048203/ Төслийн санхүүжилт	68,120.64
23	Голомт /2205106491/ \$	368,013.44
Нийт мөнгөн хөрөнгө		3,245,111,747.14

Авлагын талаар:

“Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн авлага дансанд 2014-2023 оны хооронд үүссэн нийт 51,889,333,764.18 төгрөгийн авлага бүртгэлтэй байна. Үүнээс тооцоо нийлсэн акттай 1,308,859,690.05 төгрөгийн авлага, шүүхийн шийдвэр гарсан 18,061,705,042.34 төгрөгийн авлага байна.

“Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн 2024 оны хагас жилийн байдлаарх нийт авлагын дэлгэрэнгүй танилцуулга				
		2024.06.30-ны байдлаар		
№	Дансны нэр	Холбогдох байгууллага	2023.12.31	2024.06.30
1	Нийт энгийн түрээсийн авлага		422,172,121.51	419,915,868.51
		Дархан аймаг 1 блок	10,504,193.81	14,914,193.81
		Сэлэнгэ аймаг 1-р байр	24,710,944.00	15,519,000.00
		БУХ-2 түрээс 1001 байр	176,167,532.70	173,281,530.70
		Ховд аймаг 1-1-р орц	29,168,420.00	23,836,020.00
		Увс түрээс 27-р байр	37,638,413.00	32,246,413.00
		Архангай түрээс 41-р байр	44,279,554.00	44,290,554.00



ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ4000

		Хангай хотхон түрээс 223	45,357,000.00	61,907,000.00
		Хэнтий аймаг Бор-Өндөр 52 байр түрээс	22,190,000.00	19,235,000.00
		Хэнтий аймаг Шинэ өндөр хаан түрээс	27,905,264.00	30,960,357.00
		Хэнтий 30 айл түрээс	4,250,800.00	3,725,800.00
2	Дансны авлага		4,174,902,203.36	4,154,718,959.17
		ТОСКҮЭХ	1,167,920.00	1,167,920.00
		НШШГГ	289,384,420.00	289,384,420.00
		Петро стар ХХК	3,013,351.00	2,648,288.63
		СУМ ТӨСӨЛ-Хөдөлгөөнт тоног төхөөрөмж гаалиар түр горимоор нэвтрүүлэхэд үүссэн НӨАТ авлага	2,197,233,976.36	2,197,233,976.36
		Нью Роял Энержи ХХК	-	181,818.18
		Азийн хөгжлийн банк	9,000,000.00	9,000,000.00
		Өсөлт Хөгжил	4,935,000.00	4,935,000.00
		Хэнтий аймаг ЗДТГ	1,670,167,536.00	1,650,167,536.00
3	Дансны авлага/ХХб-сум төсөл \$	Хөгжлийн банк	3,820,992,142.51	3,820,992,142.51
4	Дансны авлага- Сум төсөл \$	Хөгжлийн банк	26,774,561,777.57	26,774,561,777.57
5	Найдваргүй авлагын хасагдуулга		-1,682,182,530.62	(1,682,182,530.62)
6	Ажилчдаас авах авлага		-	4,020,838.66
7	Хувь хүмүүсээс авах авлага		11,599,852.00	10,499,852.00
		1007-49 тоот Мэнд-Амгалан	48,618.00	48,618.00
		1015-42 тоот Ц.Батцэцэг	53,960.00	53,960.00
		27-22 Х.Долгорсүрэн	317,719.00	317,719.00
		711-47 Б.Батзаяа	2,636,800.00	2,636,800.00
		725-38 Э.Ням-Очир	156,480.00	156,480.00
		728-26 Ариунаа	225,000.00	225,000.00
		З.Баттогтох	3,460,000.00	3,460,000.00
		Хэнтий 52-16 Б.Энхжаргал	39,000.00	39,000.00
		Хэнтий 52-05 Д.Дэлгэрмаа/Шүүхийн шийдвэрээр	4,662,275.00	3,562,275.00
8	40000 иргэдээс авах байрны төлбөр		119,618,018.81	100,094,018.81
		Архангай аймаг Агиймаа/их тамир/-3 тоот	255,400.00	255,400.00
		Баян-Өлгий аймаг Д.Алима /Баян-Өлгий 40-31/	14,054,000.00	0.00
		Баян-Өлгий Х.Сьезд /Баян-Өлгий 40-35,36,37/	32,335,522.00	32,335,522.00
		А.Эрдэнэбат /Баянхонгор 30-9/	300,000.00	300,000.00
		Булган аймаг О.Маша/Дашинчилэн 4,8 айл/	1,970,000.00	0.00
		Булган аймаг Д.Дэлгэрмаа/Рашаант 4,8 айл/	7,000,000.00	7,000,000.00
		Булган аймаг Н.Мөнхдулам /Дашинчилэн3,4 тоот/	5,549,999.81	4,049,999.81
		Говь-Алтай аймаг П.Баясгалан /ГАА 20-11/	500,000.00	0.00
		Говь-Алтай аймаг Ж.Чулуунбат /Цогт/	1,300,000.00	1,300,000.00
		Говь-Алтай аймаг Х.Нармандах Чандмань	2,900,000.00	2,900,000.00
		Говь-Алтай аймаг Ч.Ганхүлэг /Бигэр/ С.Энхтуяа	1,300,000.00	1,300,000.00
		Говь-Алтай аймаг Г.Баттогтох/ Баян-Уул	1,500,000.00	1,500,000.00
		Говь-Алтай аймаг Б.энхбаяр /Цогт/	3,300,000.00	3,300,000.00
		Говь-Алтай аймаг Нармандах/Чандмань 4 тоот	3,153,400.00	3,153,400.00
		Говь-Алтай аймаг Цэцэгээ /Тайшир/ - 6,7 тоот	3,270,800.00	2,270,800.00
		Говь-Алтай аймаг Н.Ганзориг /Тайшир/ 3,4 тоот	2,820,000.00	2,820,000.00
		Говь-Алтай аймаг Ц.Арвижих /Тайшир/ 5 тоот	3,155,828.00	3,155,828.00

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ4000

	Говь-Алтай аймаг Алтангэрэл /Тайшир/ 1 тоот	120,000.00	120,000.00
	Дорнод Ц.Болормаа/ Сэргэлэн	590,000.00	590,000.00
	Дорнод Ч.Мөнхцэцэг/Сэргэлэн/ Зтоот	545,000.00	545,000.00
	Дорнод Ганболд /Баян-Түмэн/	600,000.00	600,000.00
	Завхан Б.Цогтжаргал/Их уул 4 айл 98848464	411,269.00	411,269.00
	Завхан Б.Мягмардорж	642,812.00	642,812.00
	Завхан Батцэнгэл/Рашаант	2,000,000.00	2,000,000.00
	Орхон С.Мөнхцэцэг /Жаргалант	2,000,000.00	2,000,000.00
	Орхон Ч.Алтанхуяг /Жаргалант	3,426,920.00	3,426,920.00
	Орхон Д.Гэрэлцогт/Жаргалант	2,000,000.00	2,000,000.00
	Өвөрхангай М.Нямсүрэн /Өвөрхангай 12-11/	1,338,738.00	1,338,738.00
	Сэлэнгэ Ч.Ганхуяг	1,000,000.00	1,000,000.00
	Ч.Хишигжаргал/баруунбүрэн		
	Увс Э.Жавзан/увс наранбулаг/	500,000.00	0.00
	Ховд Д.Нямбаяр /Ховд 38-31/	278,330.00	278,330.00
	Ховд У.Батмөнх/Булган	14,000,000.00	14,000,000.00
	Хөвсгөл Ш.Далантай/ Их уул	3,500,000.00	3,500,000.00
	Хөвсгөл Ж.Ариунаа/Тосонцэнгэл	2,000,000.00	2,000,000.00
9	Хөрөнгө оруулалтын авлага	15,081,381,876.37	15,061,381,876.37
	НМХГ-60 /Зумбоо ХХК/	3,070,075.77	3,070,075.77
	Могоул Скай ХХК	3,398,090,000.00	3,398,090,000.00
	Бүрд Констракшн ХХК /УПЕГ/	105,277,128.28	85,277,128.28
	Үндэсний барилга консерциум ХХК	950,000,000.00	950,000,000.00
	Ти Ти энд Би ХХК	2,128,670.30	2,128,670.30
	БЭРЭН ГРУПП ХХК	9,000,000,000.00	9,000,000,000.00
	Шинэ мянганы констракшн ХХК	1,200,000,000.00	1,200,000,000.00
	ЖИДИ ХХК	422,816,002.02	422,816,002.02
10	Хөрөнгө оруулалтын авлага/Шинэ яармаг/	0.01	0.01
11	Компани хоорондын авлага	49,978,033.13	50,228,033.13
	Каркас зураг ХХК	5,162.62	5,162.62
	Си Эф Си групп"ХХК	26,400,000.01	26,400,000.01
	Ти Ти Эф Ар ХХК	4,500,000.00	4,500,000.00
	Шинэ мянганы констракшн ХХК-шүүхийн тэмдэгтийн хураамж	9,447,616.00	9,447,616.00
	ЖИДИ ХХК	9,625,254.90	9,625,254.90
	Хэрэм Зам ХХК	(0.40)	(0.40)
	КоллПро ХХК	-	250,000.00
12	Иргэдээс авах авлага / орон сууц	111,197,537.70	44,667,537.70
	1017-17 Б.Ялалтбаяр	4,455,000.00	2,970,203.39
	1027-28 М.Доржпагма	1,238,500.00	1,238,500.00
	1027-37 Ш.Амарзаяа	20,068,217.70	15,068,217.70
	728-04 Б.Мөнхтүвшин	8,269,020.00	8,269,020.00
	Дархан - 189 1-76 Алтансүх	26,800.00	26,800.00
	Дорнод Залуус хороолол 9-8 Б.Баярмагнай	3,225,000.00	-
	Дорнод Залуус хороолол 3-3-2 Үүрийнтуяа	4,690,000.00	-
	Дорнод Залуус хороолол 3-1-2 Э.Нарангарав	4,000,000.00	4,000,000.00
	Дорнод Залуус хороолол 3-1-4 Г.Гантулга	11,045,000.00	2,000,000.00
	Дорнод Залуус хороолол 3-4-3 Г.Баттулга	35,700,000.00	-
	Дорнод Залуус хороолол 3-4-4 Т.Номинтөлдөр	4,415,000.00	-
	эко яармаг2 1027-45 Д.Билгүүнзул 53,055,000	6,505,000.00	6,505,000.00
	эко яармаг2 1028-46 Б.Цэрэнтогтох /53055000/	7,560,000.00	7,560,000.00
13	Иргэдээс авах авлага / Авто зогсоол /	793,091,442.55	595,920,888.70
	1009-1011-р байрны зогсоол	138,000.00	-



ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ4000

		Граж D	243,454,875.69	182,260,383.75
		Граж А	250,584,277.30	202,015,647.01
		Граж В	128,334,009.41	97,219,785.31
		Граж С	154,366,715.06	101,626,941.01
		Ховд аймаг-120 автозогсоол	13,440.00	0
		Хэнтий 120 автозогсоол	16,200,125.09	12,798,131.62
14	хүүгийн авлага		1,151,440,903.85	1,151,440,903.85
		НМХГ-60 /Зумбоо ХХК/	12,426,064.00	12,426,064.00
		Могул Скай ХХК-хүү алданг авлага	725,764,839.85	725,764,839.85
		Үндэсний барилга консерциум ХХК	152,583,333.00	152,583,333.00
		Шинэ мянганы констракшн ХХК-Хүүний авлага	260,666,667.00	260,666,667.00
15	Барилгын санхүүжилтын авлага 40000		1,048,010,454.11	1,048,010,454.11
		Баянхонгор 20 айл	44,714,059.00	44,714,059.00
		Булган 30 айл	186,870,164.00	186,870,164.00
		Цома	112,178,980.00	112,178,980.00
		Форум-Арт ХХК	6,727,273.00	6,727,273.00
		Тоникен ХХК	3,700,000.00	3,700,000.00
		Ви Ти Икс" ХХК	10,909,091.36	10,909,091.36
		Эм Си Си Си конпорейшн ХХК	1,527,272.73	1,527,272.73
		Дундговь 30 айл	53,092,104.00	53,092,104.00
		Завхан 20 айл	3,631,779.29	3,631,779.29
		Увс 20 айл Амарсанаа	52,112,561.73	52,112,561.73
		Увс 30 айл	572,547,169.00	572,547,169.00
16	Барилгын санхүүжилтын хүүгийн авлага /4000 эргэн төлөлтийн /		103,446.67	103,446.67
		Тоникен ХХК	65,366.67	65,366.67
		Эм Си Си Си конпорейшн ХХК	38,080.00	38,080.00
17	Барилгын санхүүжилтын хүүгийн авлага /Ги Ти Энд Би ХХК /		129,579.70	129,579.70
18	Барилгын санхүүжилтийн авлага	Хайбрид Хаус ХХК	126,000,000.00	126,000,000.00
19	Бусад авлага		207,163,890.29	207,163,890.29
		Шинэ мянганы констракшн ХХК-алданги	197,266,665.29	197,266,665.29
		Дорнод НАА ХХК	9,897,225.00	9,897,225.00
20	НӨАТ-ын авлага		584,632.38	(2,179,243.79)
21	ХАОАТ-ын авлага		112,430.83	112,430.83
22	ҮХХӨАТ-ын авлага		3,733,040.00	3,733,040.00
	Нийт авлага		52,214,590,852.73	51,889,333,764.18

Өр төлбөрийн талаар:

"Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК-ийн богино хугацаат өр төлбөр 69,250,638,493.79 төгрөг, урт хугацаат өр төлбөр 231,830,556,428.86 төгрөг , нийт өр 301,081,194,922.65 төгрөг байна. Үүнээс тооцоо нийлсэн акттай 284,053,748,220.90 төгрөгийн өглөг, шүүхийн шийдвэрээр өглөгийг хэрэгсэхгүй болгосон 97,694,608.30 төгрөгийн өглөг, шүүхийн шийдвэрээр төлөх өглөг 1,295,214,189.58 төгрөг, Үндэсний аудитын газар Гаалийн ерөнхий газарт өгсөн албан шаардлагын дагуу Аудитын шалгалтын орлого дансанд төлдөг 364,240,940.93 төгрөгийн өглөг байна.

"Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК-ийн 2024 оны хагас жилийн байдлаарх нийт өр төлбөрийн дэлгэрэнгүй танилцуулга

2024.06.30

№	Дансны нэр	Холбогдох байгууллага	2023.12.31	2024.06.30
i	Дансны өглөг		15,361,575,367.36	15,362,030,789.46
		Галдеш ХХК	460,000.00	460,000.00
		ТОСКҮЭХ	490,310.00	490,310.00
		Баянгийн говь ХХК	-	455,422.00
		ЧД.Татварын хэлтэс	364,240,940.93	364,240,940.93
		Төрийн банк	-	0.10
		Сангийн яам	14,986,720,800.00	14,986,720,800.00
		Баяндэмбэрэл ХХК	1,804,545.45	1,804,545.45

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ4000

		Ихэр Мөнх ХХК	6,978,771.00	6,978,771.00
		Оргил цамхаг констракшн	880,000.00	880,000.00
		Грийн солюшн консалтинг ХХК	(0.02)	(0.02)
2	ҮЭ өглөг		2,414,350.10	2,414,350.10
		АНУЖИН	(1,300.00)	-1,300.00
		ТОСК Үйлдвэрчний Эвлэлийн хороо	2,415,650.10	2,415,650.10
4	Цалингийн өглөг		815,584.14	529,578.30
	Ажилчдад өгөх өглөг		74,231.16	936,265.77
5	Хувь хүмүүст өгөх өглөг		1,125,565,361.22	1,122,612,052.62
7	Байгууллагад өгөх өглөг		12,361,851,941.15	12,361,851,941.15
		Юнителком ХХК	812,525.25	812,525.25
		Сангийн яам	12,302,596,598.00	12,302,596,598.00
		Таравчинбүүлэн ХХК	154,855.00	154,855.00
		ТҮВШИНЖИН ХХК	(1.10)	(1.10)
		Хөх бүрдний эх ХХК	58,287,964.00	58,287,964.00
8	Магадлашгүй ажлын зардал	Си Эйч Си ХХК	50,205,395.88	50,205,395.88
9	Бусад богино хугацаат өглөг	Хөгжлийн банк	25,649,932,438.09	25,649,932,438.09
10	Бондын хүүгийн өглөг		462,376,712.32	462,376,712.33
11	ХАОАТ-ын өглөг		31,039,726.58	66,301,798.83
	НӨАТ-ын өглөг		-	9,188,500.00
	Орлогын татварын өглөг		-	(74,726,711.88)
	Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан АТ - ТТ-12		10,000.00	10,000.00
	Бэлтгэн нийлүүлэгчдэд өгөх өглөг /Си Эйч Си ХХК/		10,093,903.40	10,093,903.40
	Чанарын баталгааны өглөг		1,710,052,514.58	1,600,961,605.49
		Таван үндэс ХХК /БУХ-2/	1,070,250.00	1,070,250.00
		Атимос трейд ХХК	50,586,817.00	50,586,817.00
		Форум-Арт ХХК	484,500.00	484,500.00
		Юнителком ХХК	224,776.55	224,776.55
		Си Эйч Си ХХК	139,495,304.83	139,495,304.83
		Инерци ХХК	3,033,506.05	3,033,506.05
		ТҮВШИНЖИН ХХК	1,686,363.63	1,686,363.63
		Инженер геодези ХХК	9,974,417.50	9,974,417.50
		Монтех дистрибьюшн ХХК	1,166,700.00	1,166,700.00
		Мөнхийн Ундраа Увс ХХК	97,694,608.30	97,694,608.30
		Үндэсний бүтээн байгуулалтын корпораци ХХК	1,403,849,676.67	1,294,758,767.58
		МОГСУ ХХК /Хэнтий 30 айл/	785,594.00	785,594.00
		Дүрт Уул ХХК	0.05	0.05
12	Зохиогчийн хяналтын зардлын өглөг		19,681,532.92	19,681,532.92
		Буянт Ухаа1 /Карказ зураг ХХК/	11,386,881.52	11,386,881.52
		Очир Ундраа ХХК	8,294,651.40	8,294,651.40
14	Урьдчилж орсон орлого		172,589,837.00	82,447,337.00
15	Иргэд- байрны урьдчилгаа төлбөр		376,285,477.00	376,285,477.00
16	Иргэд-гражийн урьдчилгаа төлбөр		625,944,941.09	495,771,358.39
17	Иргэд-Түрээсийн орон сууцны төлбөр		9,914,947,765.42	11,651,734,168.94
		Нийт Богино хугацаат өр төлбөр	67,875,457,079.41	69,250,638,493.79
18	Иргэдийн урт хугацаат зээл-Сангийн яам /14,9 тб/		14,657,644,985.36	14,657,644,985.36
19	Урт хугацаат зээлийн хүүгийн өглөг		9,947,548,212.73	9,947,548,212.73
	Хөгжлийн банканд өгөх түрээсийн өглөг		24,086,358.29	25,363,202.29
11	Урт хугацаат бондын өглөг		180,500,000,000.00	180,500,000,000.00
15	Бусад урт хугацаат өглөг		22,000,000,000.00	26,700,000,000.00
	Урт хугацаат зээлийн хүүгийн өглөг /БУХ-2-\$/		(0.10)	(0.10)
	Хөрөнгө оруулалтын өглөг 50сая\$		28.49	28.49
		Урт хугацаат өр төлбөр	27,129,279,584.77	31,830,556,428.77
		Нийт өр төлбөр	95,004,736,664.18	301,081,194,922.56



5.2 Төрийн өмчийн түрээсийн орон сууцыг түрээслүүлэх, өмчлүүлэх ажлыг нийслэлд зохион байгуулах ажлын талаар:

Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Түрээсийн орон сууц хөтөлбөр”-ийн хүрээнд Төрийн өмчийн түрээсийн орон сууцны санд бүртгэлтэй, Улаанбаатар хотод 787, орон нутагт 733, нийт 1520 айлын орон сууц байна. /Хүснэгт-1/

№	ЗОРИЛТОД БҮЛГИЙН ИРГЭДИЙН АНГИЛАЛ БОЛОН ТАВИГДАХ ШААРДЛАГА	Байршил		Орон сууцны тоо	Батлагд сан квот /хувь/	Эзлэх хувь
		787 айл	733 айл			
1	3.6. ЗАЛУУ ГЭР БҮЛ /2017.03.01-өөс өмнө батлуулсан, 35 хүртэлх насны эхнэр, нөхөр/	УБ хот		139	20	17.7
		Орон нутаг		70	10	9.5
2	3.7. ТӨРИЙН АЛБАН ХААГЧ /Төрийн албаны тухай хуулийн 11.1-д зааснаар ажиллаж байгаа/	УБ хот		164	25	20.8
		Орон нутаг		266	30	36.3
3	3.8. ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧ /нийгмийн даатгалын шимтгэл төлдөг, орлогоо баримтаар нотолсон иргэн/	УБ хот		226	20	28.7
		Орон нутаг		126	20	17.2
4	3.9. 18 ХҮРТЭЛХ НАСНЫ 4 БА ТҮҮНЭЭС ДЭЭШ ХҮҮХЭДТЭЙ ГЭР БҮЛ /0-18 насны төрсөн болон үрчлэн авсан хүүхэд бүрийн төрсний гэрчилгээний хуулбар/	УБ хот		9	5	1.1
		Орон нутаг		5	5	0.7
5	3.10. ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭЦЭГ, ЭХ /нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.8-д заасан./	УБ хот		55	5	7.2
		Орон нутаг		33	5	4.5
6	3.11. ӨНДӨР НАСНЫ ТЭТГЭВЭР ТОГТООЛГОСОН АХМАД НАСТАН /ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 3.1-т заасан /	УБ хот		130	15	16.5
		Орон нутаг		167	20	22.8
7	3.12. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭН, ТҮҮНИЙГ ХАЛАМЖИЛДАГ ГЭР БҮЛ /ХБ хүний эрхийн тухай хуулийн 4 бүлгийн 4.1.1-д заасан иргэн/	УБ хот		61	5	7.8
		Орон нутаг		33	5	4.5
8	3.13. ГАМШИГ, АЮУЛТ ҮЗЭГДЛИЙН УЛМААС ОРОН ГЭРГҮЙ БОЛСОН ИРГЭН /шалтгаан, нөхцөл, хугацаа, хохирлын хэмжээг тодорхойлсон аймаг, нийслэлийн гамшгаас хамгаалах төрийн байгууллагын дүгнэлт/	УБ хот		23	5	2.9
		Орон нутаг		13	5	1.8
Нийт		1520		787	100	100
				733	100	100

### ТҮРЭЭСИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэмлэн Засгийн газрын 2015 оны 248 дугаар тогтоолоор баталсан “Түрээсийн орон сууц” хэрэгжүүлэх Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 25 дугаар тушаалаар “Төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай”

Түрээсийн мкв үнэ:

- Улаанбаатар- 6,000 төг
- Орон нутаг- 4,500 төг

№	Байршил	Нийт	Өмчлөх	Түрээс
1	Улаанбаатар хот	787	496	291
2	Орон нутаг	733	398	335
Нийт		1520	894	626



2020-2024 онуудад түрээсийн орон сууцанд хамрагдсан иргэдийн судалгаа

2024.12.19

№	Байршил	Орон сууцны тоо/өдх/	2020		2021		2022		2023		2024	
			Цуцлагдсан	Шинээр орсон	Цуцлагдсан	Шинээр орсон	Цуцлагдсан	Шинээр орсон	Цуцлагдсан	Шинээр орсон	Цуцлагдсан	Шинээр орсон
1	Буянт-Ухаа 2	564	32	32	3	3	9	9	1	1		
2	Хангай хотхон	223	12	12	3	3	3	3				
	Улаанбаатар хот	787	44	44	6	6	12	12	1	1		
1	Увс	105	5	5					1	1		
2	Пархан	152	2	2	1	1	1	1				
3	Сэлэнгэ	102	6	6								
4	Архангай	120	4	4			1	1			1	1
5	Хэнтий	138	1	1	1	1	2	2	1	1		
6	Ковд	116	2	2	1	1					1	1
	Орон нутагт	733	20	20	3	3	4	4	2	2	2	2
	Улсын хэмжээнд	1520	64	64	9	9	16	16	3	3	2	2

5.3 Нийслэлд баригдсан орон сууцны авто зогсоол, зорийн давхар, агуулах, үйлчилгээний төвийн суурийг худалдан борлуулах, борлуулалтын орлогын төвлөрүүлэлтийн талаар:

Төрийн орон сууцны корпорацийн ерөнхий захирлын 2015 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн А/89 дугаар тушаалаар орон сууцны нэгж үнийг тогтоох тухай тушаал гаргаж байсан байна. “Буянт-Ухаа-2 хороолол”-ын орон сууцны худалдан борлуулах нэгж мкв талбайн үнийг 1,350,000 төгрөг, зорийн давхрын авто зогсоолыг 15,000,000 төгрөг, агуулахын нэгж мкв 1,100,000 төгрөгөөр тогтоосон байна.

Мөн 2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/136 дугаар тушаалаар Авто зогсоолд захиалга авах, зээлээр худалдан борлуулах журамд нэмэлт өөрчлөлтийг оруулсан.

Улаанбаатар хотод нийт төвлөрүүлэлт хийгдэх 10,651,635,000 төгрөгийн 628 объект байгаагаас 504 объект бүрэн борлуулж 9,608,497,008 төгрөгийг төвлөрүүлсэн, 116 объектийг худалдан борлуулах гэрээ хийгдэж 796,852,992 төгрөг хүлээгдэж байна. Огт борлоогүй 8 объект буюу 246,285,000 төгрөгийн эд хөрөнгө байна.

“Буянт-Ухаа –1” хороололд 458 автозогсоолоос 337 борлуулалт хийгдэж 5,473,147,008 төгрөгийг бүрэн төвлөрүүлж, 115 зогсоол борлуулах гэрээ байгуулан 540,352,992 төгрөг графикайн дагуу төлөлт хийгдэж байгаа, борлоогүй 6 буюу 66,000,000 төгрөгийн үнийн дүн бүхий авто зогсоол байна.

“Буянт-Ухаа 2” хороололд авто зогсоол 158 ширхэг борлуулалт хийгдсэн 2,205,000,000 төгрөг, 6 ширхэг суурийн барилга байгууламжаас 5 буюу 1,569,780,000 төгрөгийг төвлөрүүлж 256,500,000 төгрөгийн төвлөрүүлэлт хийгдээгүй байна. Мөн агуулахын 6 байгууламжаас 4 буюу 360,570,000 төгрөгийн борлуулалт хийгдэж, 2 агуулах буюу 180.285.000 төгрөгийн борлуулалт хийгдээгүй байна.

Буянт-Ухаа 2 хорооллын дэргэд үйлчилгээний төвийн суурийг 2016 оны 8 дугаар сарын 11-ний өдөр захиалан бариулах гэрээ байгуулж, 193-р дугаартай 272 кв.м талбай бүхий үйлчилгээний төвийн барилгын суурийг нийт 285,000,000 төгрөгөөр худалдахаар болсон. Уг гэрээний 2.5-т заасны дагуу урьдчилгаа 28,500,000 төгрөгийг төлж үлдэгдэл 256,500,000 төгрөгийг гэрээнд заасан графикт хугацааны дагуу төлөх байсан боловч төлөлт хийгдээгүй төлбөрийн үлдэгдэл үнийн дүнд дүйцүүлж оффисын өрөөг санал болгосон байна.

Мөн “Буянт-Ухаа2” хороололд 7 давхар 400 машины нэгдсэн гараж барих ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтыг 2014 онд зохион байгуулж “Си Эйч Си” ХХК-тай 9 тэрбум төгрөгийн гэрээ байгуулж 2,789 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдэж, хөрөнгө оруулалт байхгүй шалтгаанаар ажил зогссон байна.

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ: АБ4000

Д/д	Байршил	Төслийн нэр	Төрөл	Ашиглалт ад орсон он	Нийт хүчин чадал	Нийт дүн	Төвлөрүүлсэн орлого		Хүлээгдэж буй орлого		Борлуулагдаагүй үлдэгдэл	
							тоо	Мөнгөн дүн	тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
1	УБ	"Буянт-Ухаа 1" хороолол	Автозогсоол	2014	458	6,079,500,000	337	5,473,147,008	115	540,352,992	6	66,000,000
2	УБ	"Буянт-Ухаа 2" хороолол	Автозогсоол	2016	158	2,205,000,000	158	2,205,000,000	0	-		
			Суурь		6	1,826,280,000	5	1,569,780,000	1	256,500,000		
			Агуулах		6	540,855,000	4	360,570,000			2	180,285,000
<b>НИЙТ ДҮН</b>					<b>628</b>	<b>10,651,635,000</b>	<b>504</b>	<b>9,608,497,008</b>	<b>116</b>	<b>796,852,992</b>	<b>8</b>	<b>246,285,000</b>

5.4 Өргөдөл,гомдол шийдвэрлэлтийн талаар:

"Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК нь <https://erp.e-mongolia.mn/>, болон 11-11 төвөөр ирсэн нийт 310 өргөдөл, гомдол 2024 оны 11-р сарын 15-ны өдрийн байдлаар ирснээс 289 өргөдөл, гомдол шийдвэрлэж, 20 өргөдөл, гомдол хугацаа болоогүй, 1 өргөдөл гомдлын хугацаа сунгасан байна.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт:

- албан бичгээр 60,
- цахимаар 33,
- утсаар 168,
- биечлэн уулзаж 28.

Хугацаа хоцорсон өргөдөл гомдол байхгүй. Хугацаа сунгасан 1 өргөдөл гомдлыг архивын бичиг баримтаас материал шүүхэд цаг орсонтой холбоотой сунгагдсан байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдлыг хүснэгт 1, 2-т харуулав.

"Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК-д 2024 онд бусад байгууллагаас ирүүлсэн өргөдөл,гомдол, хүсэлтүүдийн шийдвэрлэлт

/2024.11.15-ны байдлаар/

Хүснэгт 1

№	Газрууд	Нийт ирсэн	Шийдвэрлэсэн	Судлагдаж байгаа	
				Хугацаандаа	Хугацаа сунгасан
1	Захиргаа удирдлагын газар	34	32	2	
2	Санхүү, хөрөнгө оруулалтын газар	47	47	0	
3	Хөрөнгийн ашиглалт, зохицуулалтын газар	188	170	18	
4	Төслийн хэрэгжилтийн газар	30	29	1	1
5	Хууль, эрх зүй, дотоод хяналтын газар	11	11	0	
<b>Нийт</b>		<b>310</b>	<b>289</b>	<b>20</b>	<b>1</b>

Хүснэгт 2

№	Өргөдөл гомдол	Нийт ирсэн	Шийдвэрлэлтийн байдал				Судлагдаж байгаа
			Шийдвэрлэж хариу өгсөн				
			Албан бичгээр	Цахимаар	Утсаар	Биечлэн	
1	Егр системээр ирсэн өргөдөл, гомдол	298	56	33	160	28	21
2	11-11 төвөөр ирсэн өргөдөл, гомдол	12	4	0	8	0	0
<b>Нийт өргөдөл гомдол</b>		<b>310</b>	<b>60</b>	<b>33</b>	<b>168</b>	<b>28</b>	<b>21</b>

## 6. АУДИТЫН ҮР ДҮН

Илэрсэн Асуудал 1	Өглөг авлагын талаар
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй
<p>Бодит байдал:</p> <ul style="list-style-type: none"> <li>- “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн 2024 оны хагас жилийн санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн болох санхүүгийн тайлангийн өглөгийн тодруулга тайланд урт хугацаат өр төлбөрийн данснуудыг тайлагнаагүйгээр “Өглөгийн тодруулга тайлан”-г 69,273,899,699.11 төгрөгөөр баталгаажуулсан байна. Санхүү байдлын тайлангийн өр төлбөрийн нийт дүн 301,079,092,925.69 төгрөг.</li> <li>- Тайлант үед санхүүгийн тайланд авлага 51,933,929,878.78 төгрөгийг тайлагнасан ба дотоод аудитын явцад авлага 51,889,333,764.18 төгрөгийн үлдэгдэлтэй болохыг тогтоосон. Авлагыг 48,615,263.88 төгрөгөөр бууруулж, 4,019,149.27 төгрөгийн авлагыг бүртгэж санхүүгийн тайланд залруулга хийгдсэн байна. 2024.06.30-ны Санхүү байдлын тайлангийн нийт өр төлбөр 301,079,092,925.69 төгрөгөөр тайлагнасан. Өглөгийн тодруулгын тайланд 301,081,194,922.65 төгрөгийн үлдэгдэлтэй байна. Өглөгийг 3,969,760.26 төгрөгөөр нэмэгдүүлж, 1,867,763.21 төгрөгөөр бууруулж залруулга хийгдсэн байна.</li> <li>- “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн авлага дансанд 2014-2023 оны хооронд үүссэн нийт 51,889,333,764.18 төгрөгийн авлага бүртгэлтэй байна. Үүнээс тооцоо нийлсэн акттай 1,308,859,690.05 төгрөгийн авлага, шүүхийн шийдвэр гарсан 18,061,705,042.34 төгрөгийн авлага байна. Үлдсэн 32,563,365,146.40 төгрөгийн авлага нь хянан баталгаажуулаагүй он дамжсан авлагууд байна.</li> <li>- “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн өр төлбөр нийт 301,081,194,922.65 төгрөг байна. Үүнээс тооцоо нийлсэн акттай 284,053,748,220.90 төгрөгийн өглөг, шүүхийн шийдвэрээр өглөгийг хэрэгсэхгүй болгосон 97,694,608.30 төгрөгийн өглөг, шүүхийн шийдвэрээр төлөх өглөг 1,295,214,189.58 төгрөг, Үндэсний аудитын газар Гаалийн ерөнхий газарт өгсөн албан шаардлагын дагуу Аудитын шалгалтын орлого дансанд төлдөг 364,240,940.93 төгрөгийн өглөг байна. Үлдсэн 15,270,296,962.94 төгрөгийн өглөгийг хянан баталгаажуулаагүй байна.</li> </ul> <p>Байх ёстой шаардлага /шалгуур/:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.4 “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна”, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжид мөрдөгдөх санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ыг үйл ажиллагаандаа өдөр тутам мөрдөн ажиллаж СТОУС-ын шаардлага хангасан санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх шаардлагатай.</li> <li>- “Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15.1 “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна”, 15.2 “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэж зааснаар залруулгыг хийх ёстой.</li> <li>- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5 “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” байгууллагын ерөнхий нягтлан бодогчийг үүрэг ба үйл ажиллагаандаа өдөр тутамдаа мөрдлөг болгон ажиллах ёстой.</li> </ul> <p>Асуудлын үндсэн шалтгаан:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн хэсгүүд тэнцүү ач холбогдолтой байдаг учир санхүүгийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрт тэнцүү ач холбогдол өгч зөв бэлтгэх хэрэгтэй. Нягтлан бодох бүртгэлдээ "Даймонд 5.0" програмыг 2014 оноос хойш ашиглаж байгаа ч</li> </ul>	



<p>санхүүгийн тайлангийн өглөгийн тодруулга тайлан программаас буруу гардаг, урт хугацаат данснуудыг харуулдаггүй гэх тайлбарыг өгч байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримтад үндэслэн залруулаагүй, зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулаагүйгээр залруулга хийгдсэн байна.</li> <li>- 2014-2023 онуудын хооронд он дамжсан өглөг авлагын тооцоог цаг тухайд нь хянан баталгаажуулж нягтлан бодох бүртгэл хийгдээгүй байна.</li> </ul>
<p>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/ Нягтлан бодох бүртгэлийн санхүүгийн тайлан үнэн зөв байх зарчмыг алдагдуулж байна. Эрх ба үүрэг, толилуулга ба илчлэл тодруулга, иж бүрэн байх батламж мэдэгдлүүд хангагдахгүй байх</p>
<p>Зөвлөмж:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн хэсгүүд тэнцүү ач холбогдолтой байдаг учир санхүүгийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрд тэнцүү ач холбогдол өгч хууль журмын дагуу зөв бэлтгэн баталгаажуулах;</li> <li>- Даймонд 5.0 програмыг байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан хөгжүүлэх талаар харилцагч байгууллагад хандаж шийдвэрлүүлэх;</li> <li>- Нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланд үндэслэн зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулж залруулах;</li> <li>- Тайлант үе бүрд өглөг, авлагын үлдэгдлийн баталгааг хийж байх</li> <li>- Он дамжсан, тооцоо нийлсэн акт үйлдээгүй өглөг авлагын нягтлан бодох бүртгэлийг нягтлан шалгах асуудал дээр мэргэжлийн зөвлөх үйлчилгээ авч нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу шаардлагатай арга хэмжээг авч ажиллах.</li> </ul>

Илэрсэн Асуудал 2	Жижиг мөнгөн сангийн үйл ажиллагаа
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй
<p>Бодит байдал:</p> <p>2024 оны эхний хагас жилийн байдлаар кассын үлдэгдэл 18,173,001.71 төгрөг, 3,509,788.97 төгрөгийн зарлага гарсан байна. “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн захирлын 2022 оны А/02 дугаар тушаалаар компанийн нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан. Тус нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн Кассын бүртгэлийн бодлого хэсэгт “Жижиг мөнгөн сангийн журам, Кассын үйл ажиллагааны журмыг хавсралт 1,2-оор үзүүлэв” гэсэн боловч баталсан журам байхгүй хавсралтыг батлаагүй байна. Кассын хязгаарыг байгууллагын дотоод үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн тодорхойлоогүй байна.</p>	
<p>Байх ёстой шаардлага /шалгуур/:</p> <p>Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2 “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж заасныг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах ёстой.</p>	
<p>Асуудлын үндсэн шалтгаан:</p> <p>“Жижиг мөнгөн сан ба кассын үйл ажиллагааны журмыг батлуулаагүй кассын, хязгаарыг байгууллагын дотоод үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн тодорхойлоогүй байна.</p>	
<p>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:</p> <p>Жижиг мөнгөн сангийн үйл ажиллагаа тодорхой бус байна.</p>	
<p>Зөвлөмж:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Жижиг мөнгөн сангийн үйл ажиллагааны журмыг батлуулж, мөрдөх.</li> </ul>	

Илэрсэн Асуудал 3	Жолоочийн тооцооны анхан шатны баримтын тухай
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй
<p>Бодит байдал:                  “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК нь 1363УНУ дугаартай Ланд 200, 3397УБА дугаартай Соната 8 авто машин жолооч Бат-Эрдэнийн нэр дээр эд хариуцагч бүртгэлтэй, 0847УНУ дугаартай Хюндай Азера машин Содномдэмбэрэлийн нэр дээр, 6059УБГ дугаартай Хюндай Старех Пүрэвдоржийн нэр дээр эд хариуцагч бүртгэлтэй байна. Хюндай Азера болон Хюндай Старех авто машиныг Солонго1,2 төслийн ажилчид ээлжлэн унаж өдөр тутам авто машины бүрэн бүтэн байдлыг хариуцах хүн байхгүй байна. Шатахууны зардлын гүйцэтгэлийг гаргахдаа жолооч жолоочийн тооцооны хуудсыг бүрэн бөглөөгүй хэдэн км явснаа хянаад гарын үсэг зураагүй байна.</p>	
<p>Байх ёстой шаардлага /шалгуур/: Сангийн сайдын 2017 он 347 дугаар “Маягт, заавар батлах тухай” тушаалаар жолоочийн тооцооны хуудсыг хөтлөх.</p>	
<p>Асуудлын үндсэн шалтгаан:                  Шатахууны зардлын гүйцэтгэлийг гаргахдаа “жолоочийн тооцооны хуудас”-ыг дутуу хөтөлсөн байна.</p>	
<p>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:                  Шатахууны хэмнэлт, хэтрэлтийг тооцох боломжгүй</p>	
<p>Зөвлөмж:                  1. Тээвэр шатахууны зардалд зарцуулсан орлого, зарлагын тооцоог сар бүр хийж үлдэгдлийг тулган баталгаажуулах;                  2. Хюндай Азера болон Хюндай Старех авто машины жолоочийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж, авто машины бүрэн бүтэн байдлыг хариуцуулах.</p>	

Илэрсэн Асуудал 4	ТУЗ-ын гишүүдийн нийгмийн даатгалын шимтгэлийн тухай
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй
<p>Бодит байдал:                  “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүний бүрэлдэхүүнтэй. ТУЗ-ийн гишүүдийн нийгмийн даатгалыг 40,001 Даатгуулагчийн төрлийн кодтой “Үндсэн ажлаас гадуур зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа ажилтан” даатгуулагчийн төрлөөр ажил олгогч 10.5 хувиар, даатгуулагч 10.5 хувиар тооцож нийгмийн даатгалын шимтгэлийг төлсөн байна.</p>	
<p>Байх ёстой шаардлага /шалгуур/:                  Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ын 7.3.1 дэх заалт, 18.1 дэх хэсэг, 21.9 дэх хэсэгт зааснаар 75001 даатгуулагчийн төрлийн кодтой “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн” даатгуулагчийн төрлөөр ажил олгогч 12 хувиар, даатгуулагч 11.3 хувиар тооцож нийгмийн даатгалын шимтгэл төлөх ёстой.</p>	
<p>Асуудлын үндсэн шалтгаан:                  Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ын 32.2.2 ажил олгогч “...нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх” гэж заасантай нийцэхгүй байна.</p>	
<p>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:                  Нягтлан бодох бүртгэлийн санхүүгийн тайлан үнэн зөв байх зарчмыг алдагдуулж байна.</p>	
<p>Зөвлөмж:                  - Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн нийгмийн даатгалын шимтгэлийг 75001 даатгуулагчийн төрлийн кодтой “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн” даатгуулагчийн төрлөөр төлөх.</p>	



Илэрсэн Асуудал 5	Орлогын татварын өглөг дансны тухай
Асуудлын ангилал	Нөлөө багатай
<p>Бодит байдал:                  “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК нь хадгаламжийн хүүгийн орлогын татвар болох 37,363,355.94 төгрөгийг Орлогын татварын өглөг /3103/ дансанд анхнаасаа бүртгээгүй буюу хүүгийн зардлыг хуримтлуулан тооцоогүй, Хүүгийн орлогын татварт 37,363,355.94 төгрөгийн хүүгийн төлбөрийг төлөх үед Орлогын татварын өглөг /3103/ дансыг бууруулсан байна. 2024.06.30-ны өдөр Орлогын татварын өглөг /3103/ дансыг бууруулж Орлогын татварын зардал /9101/ дансыг бууруулсан байна. Хүүгийн зардлыг хуримтлуулан тооцоогүй, Орлогын татварын зардлын дансны хаалтын бичилтээ хийгээгүй хагас жилийн санхүү байдлын тайлангаа гаргасан байна.</p>	
<p>Байх ёстой шаардлага /шалгуур/:                  Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжид мөрдөгдөх санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”, Сангийн сайдын 2018 оны 100 дугаар тушаалаар баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн маягт, хөтлөх аргачлал”, Сангийн сайдын 2023 оны А/229 дугаар тушаалаар баталсан “Журам шинэчлэн батлах тухай” журмуудыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах.</p>	
<p>Асуудлын үндсэн шалтгаан:                  Сангийн сайдын 2023 оны А/229 дугаар тушаалаар баталсан “Журам шинэчлэн батлах тухай” журмын 3.9 “Санхүүгийн хэрэглүүрт хамаарах хүүгийн зардлыг дараах байдлаар бүртгэнэ:                  (а) хүүгийн зардлыг хуримтлуулан тооцох үед:                  Дт Хүүгийн зардал                  Кт Хүүгийн өглөг                  (б) хүүгийн төлбөрийг төлөх үед:                  Дт Хүүгийн өглөг”                  Кт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө”, 3.12 “Тайлант үеийн эцэст орлого, зардлын дансны үлдэгдлийг орлого, зардлын нэгдсэн дансанд хааж, үр дүнг тооцон хуримтлагдсан үр дүн дансанд хаалтын бичилт хийнэ” гэсэнтэй нийцэхгүй байна.</p>	
<p>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:                  Нягтлан бодох бүртгэлийн санхүүгийн тайлан иж бүрэн, үнэн зөв байх зарчмыг алдагдуулж байна.</p>	
<p>Зөвлөмж:                  - Санхүүгийн хэрэглүүрт хамаарах хүүгийн зардлыг хуримтлуулан бүртгэж хэвших.</p>	

Илэрсэн Асуудал 6	Шилэн дансны мэдээлэл хөтлөлтийн талаар
Асуудлын ангилал	Нөлөө багатай
<p>Бодит байдал:                  “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн шилэн дансны мэдээлэлд 2023 онд Шилэн дансны тухай хуулийн хүрээнд хугацаа хоцорсон 3 мэдээлэл байна. 2024 оны 11 дүгээр сарын байдлаар Шилэн дансны тухай хуулийн хүрээнд хугацаа хоцорсон 2 мэдээлэл байна.</p>	
<p>Байх ёстой шаардлага /шалгуур/: Шилэн дансны тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоол “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ыг өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллах ёстой.</p>	

Асуудлын үндсэн шалтгаан:

Шилэн дансны хуулийн 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” шилэн дансны зарчмыг алдагдуулсан байна.

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Хуулийн дагуу хугацаа хоцорсон болон шилэн дансанд мэдээлэх мэдээллийг оруулаагүйгээс болж эрх бүхий албан тушаалтанд хариуцлага тооцогдох, бусад хөндлөнгийн хяналт шалгалтад хамрагдах, олон нийт нийгэмд үзүүлэх сөрөг хандлага зэрэг олон сөрөг нөлөөтэй.

Зөвлөмж:

- Шилэн дансанд байршуулах мэдээллийг хуулийн хугацаанд иж бүрэн байршуулах.

Илэрсэн Асуудал 7	Дотоод хяналтын талаар
Асуудлын ангилал	Нөлөө багатай

Бодит байдал:

“Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК 2022 болон 2023 онуудад дотоод хяналтын талаар хэрэгжүүлсэн хяналт шалгалт байхгүй. 2024 оны хувьд Төрийн орон сууцны корпорацийн гүйцэтгэх захирлын 2024 оны А/25 дугаар тушаалаар “Дотоод аудит, хяналт шалгалтын төлөвлөгөө”-г батлуулсан байна.

Дотоод аудитын 2024 оны төлөвлөгөөнд 4 ажил төлөвлөгдсөнөөс 2 ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнээс:

- Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийх ажлын удирдамжийг гүйцэтгэх захирал баталж 2024 оны 05 дугаар сарын 24-ны өдрөөс 06 дугаар сарын 07-ны өдрийн хугацаанд дотоод аудитыг хийж Дотоод аудитын ажлын тайланг бэлтгэн 2 зөвлөмж өгч ажилласан байна.

- Компанийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх ажлын удирдамжийг гүйцэтгэх захирал баталж 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдрөөс 10 дугаар сарын 12-ны өдрийн хугацаанд дотоод аудитыг хийж Дотоод аудитаар “сайжруулах шаардлагатай” гэсэн дүгнэлтийг өгч, 9 зөвлөмж өгч ажилласан байна.

Компанийн дотоод хяналт шалгалтын 2024 оны төлөвлөгөөнд 6 ажил төлөвлөгдсөн байна. Үүнээс 2 ажлын хүрээнд “Компанийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийх ажлын удирдамж”-ийг гүйцэтгэх захирлаар батлуулан шалгалтыг 2024 оны 04 дүгээр сарын 08-ний өдрөөс 05 дугаар сарын 25-ны өдрийн хооронд гүйцэтгэж аудитын ажлын тайланг эцэслэн баталгаажуулаагүй байна.

Байх ёстой шаардлага /шалгуур/:

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 3.4 дэх заалт, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм-н дагуу Төрийн орон сууцны корпорацийн гүйцэтгэх захирлын 2024 оны А/22 дугаар тушаалаар “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”, 2024 оны А/23 дугаар тушаалаар Дотоод аудитын үйл ажиллагааг зохион байгуулах журам”-г батлуулан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах ёстой.

Асуудлын үндсэн шалтгаан:

“Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК нь 2022 болон 2023 онуудад Дотоод хяналтын төлөвлөгөө батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаагүй байна. 2024 оны байгууллагын дотоод аудит, хяналт шалгалтын төлөвлөгөө 100 хувь хэрэгжээгүй байна.

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Байгууллагын дотоод хяналтын систем суларна.

Байгууллагын үнэ цэнэ буурна, төсөв санхүүгийн хүндрэл учирч хэвийн үйл ажиллагаа алдагдана.

**Зөвлөмж:**

- Дотоод аудит, хяналт шалгалтын ажлыг төлөвлөгөөний дагуу цаг хугацаанд нь хэрэгжүүлж, дотоод хяналтын ажлыг эрчимжүүлэх.

Илэрсэн Асуудал 8	Үндэсний аудитын газраас тус байгууллагын үйл ажиллагаанд 2023 онд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлээгүй талаар.
Асуудлын ангилал	Нөлөө багатай.
<p>Бодит байдал:</p> <ul style="list-style-type: none"> <li>➢ 17 компани буюу 41% нь бодит бус авлага тул дансны бичилтээр залруулга хийх шаардлагатай тул ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.</li> <li>➢ Түрээсийн орон сууцны 938 иргэний авлагыг тулгаж дуусгасан. 26 иргэний нийт 110.686.222.81 төгрөгийн төлбөрийг барагдуулж хамтарч ажиллах талаар сум тус бүрийн ЗДТГ-т албан бичиг хүргүүлсэн.</li> <li>➢ Хөгжлийн банкны өр төлбөр барагдуулахтай холбоотой саналыг БХБЯ-нд хүргүүлсэн.</li> </ul>	
<p>Байх ёстой шаардлага /шалгуур/:</p> <p>77 аж ахуйн нэгж, 960 ирнээс авах нийт 21.407.4 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг харилцагч тус бүрээр тооцоо нийлсэн актаар баталгаажуулах. Өр төлбөрийг барагдуулах арга хэмжээг авсан байх</p>	
<p>Асуудлын үндсэн шалтгаан:</p> <p>Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, олон жилийн насжилттай авлагыг барагдуулаагүй, зөрчлийг арилгаж биелэлтийг ирүүлэх. Хөгжлийн банкнаас авсан зээлтэй холбоотойгоор үүссэн өр төлбөрийг барагдуулаагүй талаар дээд шатны төсвийн захирагчид хандаж арга хэмжээ аваагүй, өр төлбөрийг барагдуулаагүй зөрчлийг арилгах.</p>	
<p>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:</p> <p>Байгууллагын үнэ цэнэ буурна , төсөв санхүүгийн хүндрэл учирч хэвийн үйл ажиллагаа алдагдана.</p>	
<p><b>Зөвлөмж:</b></p> <p>- Үндэсний аудитын газраас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах;</p>	

Илэрсэн Асуудал 9	Төрийн өмчийн түрээсийн орон сууцыг түрээслүүлэх, өмчлүүлэх ажлыг зохион байгуулах ажлын талаар
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй
<p>Бодит байдал:</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 248 дугаар тогтоолоор баталсан “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийн хүрээнд Төрийн өмчийн түрээсийн орон сууцны санд бүртгэлтэй 1520 айл байна. Түрээсийн орон сууцанд хамрагдахаар хүсэлт гаргасан иргэдийг холбогдох журмын дагуу эрэмбэлж, иргэдийн материалыг зорилтот бүлэг тус бүрээр гарган жагсаалтын сан үүсгэж гэрээ цуцлагдсан айлуудын бүртгэлийг хасаж, шинээр гэрээ байгуулж түрээсийн орон сууцанд хамрагдаж буй иргэдийн бүртгэлийг шинэчлэн бүртгэх ажлыг хэрэгжүүлэхгүй байгаа нь шалгалтын явцад илэрсэн.</p> <p>Иргэдээс ирсэн өргөдөл, гомдолд дурдсан нэр бүхий 13 иргэнтэй холбогдох зөрчлийг Барилга, хот байгуулалтын яамны Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газраас илрүүлснийг Авлигатай тэмцэх газар шалгаж байна.</p>	
<p>Байх ёстой шаардлага /шалгуур/:</p> <p>1. Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 26 дугаар тушаалаар батлагдсан “Зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам”-ын 5.1-д “Түрээсийн орон сууцанд хамрагдах шаардлага хангаж, бүртгүүлсэн</p>	



иргэдээс энэ журмын 2.2-т заасан ангилал, квот /хувь/-ын дагуу сонгон шалгаруулах ажлыг эрэмбэлж зохион байгуулна” гэж;

2. Төрийн орон сууцны корпорацийн ерөнхий захирлын 2017 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/45 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн өмчийн орон сууцанд зорилтот бүлгийн иргэдийг бүртгэх, сонгон шалгаруулах, түрээсийн орон сууцанд хамруулах ажлыг зохион байгуулах журам”-ын 3.15-д “Түрээсийн мэргэжилтэн, түрээсийн асуудал хариуцсан нэгжийн дарга хамтран зорилтот бүлэг тус бүрийн жагсаалт бүхий материалыг үндсэн журмын дагуу эрэмбэлж, эрэмбийн дарааллаар гэрээ байгуулах эрх олгож, ‘Орон сууц түрээслүүлэх тухай мэдэгдэл’-ийг хүргүүлнэ” гэж заасныг тус тус мөрдлөг болгон ажиллах ёстой.

Асуудлын үндсэн шалтгаан:

Төрийн орон сууцны корпорацийн ерөнхий захирлын 2017 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/45 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн өмчийн орон сууцанд зорилтот бүлгийн иргэдийг бүртгэх, сонгон шалгаруулах, түрээсийн орон сууцанд хамруулах ажлыг зохион байгуулах журам”-ын 3.14.3-д “Түрээсийн мэргэжилтэн нь шалгах хүснэгтийн дагуу шаардлага хангасан бүх материалыг зорилтот бүлэг тус бүрээр гарган, жагсаалтын сан үүсгэнэ” гэж заасныг хэрэгжүүлээгүй.

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/

Мэдээллийг иргэдэд нээлттэй ил тод болгох нь Түрээсийн орон сууцанд ашиг сонирхлын зөрчил гаргах нөхцөл байдал үүсэхээс сэргийлнэ.

Зөвлөмж:

1. Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 26 дугаар тушаалаар батлагдсан “Зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам”-ын хэрэгжилтийг хангах;

2. “Төрийн өмчийн орон сууцанд зорилтот бүлгийн иргэдийг бүртгэх, сонгон шалгаруулах, түрээсийн орон сууцанд хамруулах ажлыг зохион байгуулах журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах;

3. Холбогдох журамд заасан шаардлага хангаж түрээсийн орон сууцанд хамрагдахаар хүсэлт гаргасан иргэдийн мэдээллийг зорилтот бүлэг тус бүрээр журмын дагуу эрэмбэлсэн жагсаалтын сан үүсгэж, мэдээллийг иргэдэд нээлттэй ил тод болгох;

4. Жагсаалтын сангаас эрэмбийн дагуу сонгон шалгаруулалт хийж, тэмдэглэл үйлдэн баримтжуулж байх.

Илэрсэн Асуудал 10	“Буянт-Ухаа2” хороололд 7 давхар 400 машины нэгдсэн гараж барих ажил зогссон, хийгдсэн ажлууд чанарын шаардлага хангаагүй байгаа талаар.
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй

Бодит байдал:

“Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК нь тендер шалгаруулалтыг зохион байгуулж “Си Эйч Си” ХХК-тай 2014.09.10-ны өдрийн 2014/2-47 дугаартай 9,000,000,000 /Есөн тэрбум/ төгрөгийн төсөвт өртөг бүхий гэрээ байгуулан ажилласан байна. Тус ажил нь хэрэгжиж дуусаагүй зогссон бөгөөд 2014.10.16ны өдөр 1,800,000 төгрөг, 2014.12.09-ний өдөр 250,00,000 төгрөг, 2015.09.11-ний өдөр 739,906,096.6 төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон байна. Нийт 2,789,906,096.6 төгрөгөөр санхүүжүүлсэн. Дээрх гүйцэтгэлүүдээс чанарын баталгаанд 139,5 сая төгрөг, техник хяналтын зардалд 50,2 сая төгрөг, магадлашгүй ажлын зардалд 50,2 сая төгрөг нийт 239,9 сая төгрөгийн суутгал хийсэн.

Гаражын барилгын газар шороо, суурь, зоорийн давхар, каркасын ажил хийгдэж 2016 оноос санхүүжилтгүйн улмаас барилга угсралтын ажил 31 хувийн гүйцэтгэлтэйгээр ажил зогссон.

Үндэсний аудитын газраас 2018 онд ТОСК ТӨҮГ-ийн 2013-2017 оны эхний хагас жилийн байдлаарх үйл ажиллагаанд хяналт, шалгалтыг хийсэн ба аудитын явцад 400 машины гаражийн барилгын ажлын чанар, гүйцэтгэлд хяналт хийж тайланд тусгасан байна.

- Гаражийн барилгад цутгасан бетоны бат бэхийн чанарыг шалгахад зураг төсөлд заагдсан үзүүлэлтийг хангаж чадахгүй

- Бетон шал цутгах, үндсэн дам нуруу угсрах, туслах дам нуруу угсрах, баганад холбоос угсрах зэрэг ажлуудыг гүйцэтгэсэн бодит тоо хэмжээ санхүүжилт хийгдсэн тоо хэмжээнээс дутуу

- Магадлашгүй ажлын зардалд авсан болон дутуу хийгдсэн ажлын тоо хэмжээг барилгын төсвийн программаар тооцоолоход нийт 731,3 сая төгрөгийн санхүүжилтийг илүү олгосон тооцоо гарсан.

Хяналт шалгалтын дагуу 7 давхар 400 машины нэгдсэн гаражийн барилгын 0 давхрын бетон шалыг буулгаж, зураг төслийн шаардлагын дагуу дахин гүйцэтгэх тухай Үндэсний аудитын газраас Монгол улсын Ерөнхий аудиторовын 2018.05.24-ны А/128 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар албан шаардлага ирүүлж байсан байна.

Байх ёстой шаардлага /шалгуур/:

Гүйцэтгэгч нь барилга байгууламжийг батлагдсан зураг төсөл, холбогдох норм ба дүрмийн дагуу барьж гүйцэтгэх үүрэгтэй.

Барилгын тухай хуулийн 40.1.1. барилгын ажлыг зөвшөөрөл, магадлал хийгдэж, баталгаажсан зураг төсөл, норм, нормативын баримт бичгийн шаардлагын дагуу гүйцэтгэх, хяналт тавих;

40.1.2. барилгын ажлын ил, далд ажлын актыг баталгаажуулах, үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл хөтлөх, барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, зураг төсөл зохиогч, захиалагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх;

40.1.12. барилга байгууламжийн хийц, бүтээцийн даацын бат бэхийг барилгын ажлын үе шат бүрд лабораторийн шинжилгээ хийлгэж дүгнэлт гаргуулан баталгаажуулах;

Захиалагчийн техник хяналт хэрэгжүүлэгч: Барилгын тухай хуулийн 37.1.5. барилгын ажлын үе шат бүрд зохиогчийн хяналт хийлгэж, хөндлөнгийн лабораторийн шинжилгээгээр материал, хийц, бүтээц, эдлэхүүний чанар, аюулгүй байдлын техникийн үзүүлэлтүүдийг тодорхойлуулж, холбогдох зардлыг хариуцах;

37.1.7. энэ хуулийн 41 дүгээр зүйлд заасны дагуу барилгын ажлыг түр зогсоосон бол тогтоосон хугацаанд хамгаалалтын горимыг хангаж ажиллах;

37.1.12. барилгын үйл ажиллагааны хөрөнгө оруулалтын асуудлыг хариуцан зохицуулж, санхүүжилтийг тогтоосон хугацаанд хийх;

Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Барилгын ажлын захиалагчийн дүрэм"-ийн 3.1.4. Барилгын тухай хуулийн 38.1.4-т заасны дагуу зураг төсөл зохиогчтой гэрээг байгуулж, барилгын ажлын үе шатанд зохиогчийн техникийн хяналт хийлгэн дүгнэлт гаргуулж, илэрсэн зөрчлийг арилгуулах;

3.6. Захиалагч зураг төсөл зохиогч болон гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг тогтоосон хугацаанд дүгнэж, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч гэрээний дагуу хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, эсхүл зөрчил, дутагдал илэрсэн тохиолдолд гэрээ болон хууль тогтоомжид заасан хариуцлагыг тооцож ажиллана.

3.10 Захиалагч барилгын үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл, ил далд ажил болон тоног төхөөрөмжийн туршилт, тохируулга хийсэн акт, санхүүжилт зэрэг холбогдох бусад баримт бичгийг барилгын ажил гүйцэтгэх төлөвлөгөө (график), гэрээнд заасны дагуу барилгын үйл ажиллагаанд оролцогчидтой хамтран сар бүр хянан баталгаажуулна. Гэх заалтуудыг үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллах ёстой.

Гэрээний тусгай нөхцөлд заасны дагуу ажил гүйцэтгэж дуусгах хугацаа нь 2014.12.31-ний өдөр байна. Алданги ногдуулах хэмжээ нь хоногт гэрээний үнийн 0.05 хувь байна.

Асуудлын үндсэн шалтгаан: Хөрөнгө оруулалтыг бүрэн шийдвэрлээгүй тендер шалгаруулалтыг зохион байгуулсан.

Барилгын тухай хууль, Барилгын ажлын захиалагчийн дүрмийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй.

Бодит бус гүйцэтгэлийг баталгаажуулж санхүүжүүлсэн.

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Ажил хэрэгжиж дуусаагүй тул борлуулалтаар төвлөрүүлэх орлогогүй болсон. Эхлүүлсэн ажлыг үргэлжлүүлэн дуусгах, байгууламжид гарсан зөрчил, асуудлыг хэрхэх шийдвэр гаргаагүй байна.



Зөвлөмж:

- Барилга байгууламжийг хамгаалалтын горимд шилжүүлэх; /Барилгын тухай хуулийн 41.1.-д Барилгын ажлыг долоон сараас дээш хугацаагаар түр зогсоосон бол захиалагч барилга байгууламжийг хамгаалалтын горимд оруулж, энэ талаар барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагад мэдэгдэж, холбогдох шийдвэрийг гаргуулна. Барилга байгууламжийг хамгаалалтын горимд оруулах шийдвэрт хамгаалалтын горимын хугацаа, нөхцөлийг тусгана. Гэж заасан байдаг/
- Хүлээн зөвшөөрөгдсөн эрх бүхий байгууллагаар бүтээцийн бат бэх, аюулгүй байдалд тооцоо хийлгэх, дүгнэлт гаргуулж цаашид хэрхэн засварлах, хүчитгэх эсэх талаар тодорхойлуулж хэвийн байдлыг хангуулах;
- Илүү олгосон гүйцэтгэлийг гүйцэтгэгчээс гаргуулан авах;
- Үндэсний аудитын газрын албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг хангаж ажиллах.

Илэрсэн Асуудал 11	Буянт-Ухаа 2 хорооллын хажууд баригдсан 193 дугаартай 272 кв.м үйлчилгээний төвийн барилгын суурийн борлуулалтын орлогыг төвлөрүүлээгүй удсан тухай.
Асуудлын ангилал	Нөлөө багатай

Бодит байдал:

Захиалан бариулах гэрээг “Эрдэнэт төгөл” ХХК-тай 285 сая төгрөгөөр зарж борлуулахаар 2016 оны 8 дугаар сарын 11-ний өдөр байгуулсан. Гэрээнд заасан хуваарийн дагуу 2017.02.28-нд 85,500,000 төгрөг, 2017.06.30-ны өдөр 85,500,000 төгрөг, Улсын комисс ажилласны дараа 30 хувь буюу 85,500,000 төгрөг төлөх баясан боловч төлөлт хийгдээгүй. Урьдчилгаа 10 хувийг буюу 28,500,000 төгрөгийг төлсөн.

Худалдан авагч нь 2023.10.03-ны өдөр А/4523 дугаартай албан хүсэлтээр тухайн үйлчилгээний төвийн 3 давхрын 74 мкв оффисын зориулалттай талбайг 1 мкв - 3,500,000 төгрөгөөр бодож гэрээний үлдэгдэл төлбөрт 2023 оны 12 сард хүлээлгэн өгөх хүсэлтэй байгаа талаар хандсан байна.

5 давхрын 84 мкв оффисын талбайг 352 сая төгрөгт тооцуулан авахаар бичгээр тохиролцсон байна.

Байх ёстой шаардлага /шалгуур/:

Гэрээний 3.5-д Худалдан авагч талаас барилгын суурийн үнийг энэхүү гэрээнд заасны дагуу төлөхийг шаардах эрхтэй бөгөөд гэрээнд заасан хугацаанд төлөлгүй, хугацааг хуанлийн 60 хоногоос дээш хугацаагаар хэтрүүлбэл гэрээг нэг талын санаачилгаар цуцалж, урьдчилж төлсөн төлбөрийг буцаан олгож, барилгын суурийг гуравдагч этгээдэд зарах эрхтэй болно гэсэн байна.

Асуудлын үндсэн шалтгаан:

Гэрээний хариуцлага тооцоогүй байна. Суурийн графикайн дагуу төлөлт хийгдээгүй, барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Байгууллагын борлуулалтын орлого буурах, гэрээнд заасан хуваарийн дагуу төлөгдөөгүй 7 жил өнгөрсөн тул тухайн үеийн мөнгөний ханшийн зөрүү үүсэх зэрэг нөлөөтэй байна.

Зөвлөмж:

- Гэрээний заалтыг хангаж ажиллах, тооцоог яаралтай барагдуулж дуусгах;

Илэрсэн Асуудал 12	Авто зогсоолыг зээлээр худалдан борлуулахдаа гэрээний дагуу сар бүрийн төлөлтийг товлосон өдөрт нь барагдуулахгүй байгаа талаар.
Асуудлын ангилал	Нөлөө багатай
<p><b>Бодит байдал:</b> Улаанбаатар хотод авто зогсоолыг зээлээр худалдан авсан зээлийн үлдэгдэлтэй 128 иргэдээс 10 дугаар сарын төлөлт хийгээгүй /11 дүгээр сарын 27-ны өдрийн байдлаар/ 56 иргэн байна.</p> <p><b>Байх ёстой шаардлага /шалгуур/:</b> Гэрээнд заасан хугацаанд сар бүрийн төлөлтөө хийсэн байх.</p> <p><b>Асуудлын үндсэн шалтгаан:</b> Гэрээний хариуцлага тооцоогүй, хоцорсон өдрөөр алданги тооцдоггүй тул төлөлтийг цагт нь хийхгүй байна.</p> <p><b>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:</b> Байгууллагын борлуулалтын орлого буурах, гэрээнд заасан хуваарийн дагуу төлөгдөхгүй байснаар мөнгөний ханшийн зөрүү үүсэх, компанийн үйл ажиллагаанд нөлөө үзүүлнэ. /Жишээ нь сард 56 айлыг 280000 төгрөгийн төлөлт хийх ёстой гэж үзвэл 15,680,000 төгрөг төвлөрүүлэхгүй байна/</p> <p><b>Зөвлөмж:</b> - Сар бүрийн төлөлтийг төлөх өдрийг жагсаалт гарган урьдчилж мэдээлэл хүргүүлдэг байх, цаг хугацаанд нь төвлөрүүлэх;</p>	

Илэрсэн Асуудал 13	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт хуулийн хугацааг баримтлаагүй, хариу өгч, хаагаагүй, хяналт сул учир нэг төрлийн гомдол тасралтгүй ирж байна.
Асуудлын ангилал	Нөлөө багатай
<p><b>Бодит байдал:</b> Улсын комисс ажиллаж, орон нутгийн эзэмшилд хүлээлгэн өгсөн байрны ашиглалттай холбоотой бохир халих, зоорийн давхар усанд автах, дээврээс ус гоожих, айл ус алдах зэрэг өргөдөл гомдлыг хүлээн авч, тодорхой хариу өгөөгүй, хяналт тавиагүй</p> <p><b>Байх ёстой шаардлага /шалгуур/:</b> Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2, 16 дугаар зүйлийн 16.1, 16.2, 19 дугаар зүйлийн 19.1</p> <p><b>Асуудлын үндсэн шалтгаан:</b> Өргөдөл, гомдол гаргасан иргэдэд бодитой хариуг хугацаанд нь өгөөгүй, асуудлыг шийдвэрлээгүй учраас байрны ашиглалттай холбоотой иргэдийн өргөдөл, гомдол тасралгүй ирсээр байгаа.</p> <p><b>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:</b> Төрийн бодлого, шийдвэрт итгэх иргэдийн итгэл сулрах, төрийн байгууллагын нэр хүнд иргэдийн дунд буурах</p> <p><b>Зөвлөмж:</b> - Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах;</p>	

7.НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Дотоод аудитаар танай байгууллагад “Сайжруулах шаардлагатай” гэсэн дүгнэлтийг өгч байна.

Дүгнэлтийн төрөл	Дүгнэлтийн тайлбар
“Сайжруулах шаардлагатай”	<p>Засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцын төлөвшил нь “давтамжтай буюу 2-р түвшин”-д байна гэж үзсэн.</p> <p>Аудитаар илэрсэн асуудлуудын 21-79% нь “нөлөө ихтэй” гэж үзсэн.</p>

ТАНИЛЦСАН:

Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч



С.Төмөрхүү

ТАЙЛАН ХЯНАСАН:

ХШУДАГ-ын дарга бөгөөд Дотоод аудитын хорооны гишүүн



Х.Ган-Очир

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

Дотоод аудитын хорооны нарийн бичгийн дарга



Б.Цолмон-Эрдэнэ

